

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-63

<i>1.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах /</i>	14-15
<i>2.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	15-19
<i>3.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	19-30
<i>4.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар/</i>	31-63

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 15-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 19 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Д.Батлут, Б.Баярсайхан, Б.Жавхлан, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн, Ч.Хүрэлбаатар, Л.Энх-Амгалан, Ц.Цэрэнпунцаг, Ж.Эрдэнэбат;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, С.Батболд, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Сэргэлэн, Б.Энхбаяр;

Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Ц.Туваан;

Хоцорсон: Ш.Адьяаа-3 цаг 38 минут, Г.Амартүвшин-52 минут, Ж.Бат-Эрдэнэ-23 минут, Х.Болорчулуун-12 минут, Х.Булгантуяа-27 минут, С.Ганбаатар-08 минут, Г.Ганболд-19 минут, Т.Доржханд-04 минут, Б.Пүрэвдорж-3 цаг 52 минут, Б.Саранчимэг-22 минут, Д.Цогтбаатар-29 минут, Ж.Чинбүрэн-14 минут,

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, Н.Ганибал, Н.Энхболд, Д.Ганбат нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулан, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Н.Ганибал, Н.Энхболд, Д.Ганбат нар үг хэлэв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
 Татгалзсан: 4
 Бүгд: 45
 91.1 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:44/

2.Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
 Татгалзсан: 4
 Бүгд: 45
 91.1 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:45/

Уг асуудлыг 10 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Монголын банкны холбооны дэргэдэх Хуульчдын мэргэжлийн зөвлөлийн дарга М.Мөнхбаатар, Монголын Нотариатчидын танхимын Ерөнхийлөгч Ч.Баяржаргал, Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал, Монголын финтекийн холбооны гүйцэтгэх захирал М.Бямбасүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	14
Бүгд:	47
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.	

2.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалт 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4/уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих, дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршлага, ноу-хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршлага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх;

6/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо /Э.Батшугар/-нд даалгасугай.” гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	35
Татгалзсан:	12
Бүгд:	47

74.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
 Татгалзсан: 13
 Бүгд: 47
 72.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 2.Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авч болно.” гэж өөрчлөх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
 Татгалзсан: 14
 Бүгд: 47
 70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022.03.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх П.Батхишиг, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн багш М.Ундрам нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Б.Саранчимэг, Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх П.Батхишиг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Д.Сарангэрэл, С.Чинзориг, М.Оюунчимэг, Б.Жаргалмаа, Б.Бат-Эрдэнэ, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 18

Бүгд: 39

53.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 27 гишүүн Ахмадын нийгмийн хамгаалал, асаргаа, сувилал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хамтрах, төр засгаас ахмадын талаар явуулж буй арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой лобби бүлэг байгуулж байгааг уламжлав. /11:34/

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 11 цаг 34 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, мөн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай нар байлцав.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Д.Ганбат, О.Цогтгэрэл, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хуралдааныг 15 цаг 05 минутаас 15 цаг 43 минутад даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Ойн газрын дарга Б.Оюунсанаа нар хариулж, тайлбар хийв.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 15 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэдийн төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын “Хобби” сургуулийн 11^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 72 гишүүнээс 52 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 15-ны
өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 19 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгая. Хурлын ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Хуулийн төслийг эцэслэн батална. Хуулийн төслүүд эцэслэн батална. Нийт хоёр төсөл байгаа, хоёр конвенц байгаа.

Хоёрдугаарт, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод”

үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн хуульд заасан хэлэлцэхээр товлосон Дэгийн тухай хуулийн 9.5-д заасан асуудлын товыг өөрчлөх, хойшлуулах, дараалал өөрчлөх ийм горимын санал гаргах бол 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасан. Үүний дагуу 5 гишүүн ирүүлсэн байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна энд. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Айн, оронд хэлж болохгүй. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Ороод ирвэл.

Ц.Даваасүрэн: Би хоёр асуудлаар ярья гэж бодсон юм энэ хэлэлцэх асуудалтай холбогдуулаад.

Нэгдүгээрт энэ юуны асуудал байгаад байгаа юм. Энэ зудын хүндрэлтэй холбогдолтой асуудлууд.

Хоёрт энэ эрчим хүчин дээр энэ түлш шатахуун, эрчим хүчин дээр үүсээд байгаа асуудал дээр. Үүнийг бид ер нь ярих ёстой Их Хурлын түвшинд бид нар тодорхой шийдвэрүүд гаргах ёстой. Сая би зудтай сумдаар бол явлаа. Ер нь зудтай сумдын нөхцөл байдлыг харахад хамгийн хүндрэлтэй юм бол цас нь эрт ороод хөлдөөд, хатуураад мал бэлчих ямар ч боломжгүй болчихсон байна. Тэгээд малаа нэлээн нядалцаагаж байгаа юм байна. Харин яах вэ эрт болсон учраас бас тийм боломж байна. Энэ гурван зүйлийг л ер нь Улсын Их Хурал Их Хурлын гишүүддээ хандаж тавиад байгаа юм байна лээ.

Нэгдүгээрт, бидний энэ нядалж байгаа энэ малыг та бүхэн худалдаж авахад анхаараач гэж байгаа юм.

Хоёрдугаарт, өвс тэжээлийг жоохон хямдруулаад өгөөч гээ гэсэн асуудал. 50 хувь гээд яах вэ Засгийн газар дээр энэ асуудал яригдаад нэлээн нааштай ингэж болсон байгаа.

Гуравд, хүндрүүлж байгаа юм бол энэ түлш шатахуун байна гэж. Нөгөө отор нүүдэл хийх гэхээр нөгөө түлш шатахуун нь байхгүй болчихсон. Нядалсан хэдэн малаа сум оруулъя, аймгийн төв оруулъя гэхээр би бас шатахуун нь байхгүй болчихсон. Зуд дээр нь нэмээд түлш, шатахууны хямралууд нүүрлэчихлээ энэ асуудлуудыг шийдэж өгөөч гэж.

Тэгэхээр хөдөө аж ахуй дээр ялангуяа энэ малчдын хувьд бол мөн арьс ширэн дээр та нар бас тодорхой шийдвэр гаргаж өгөөч. Тэр үйлдвэрээ хэдэн жил ярьдаг юм бэ гэж бас. Энэ үнэн л дээ. Үндсэндээ энэ чинь 10 сая орчим бог гаргаж байгаа байх жилдээ. Тэгэхэд тэрний арьс гээд бодохоор 10 доллароор бодоход 100 сая доллар байгаа байхгүй юу. Одоо л 100 сая долларыг бид нар зүгээр л хаячхаж байна шүү дээ. Гэтэл 100 сая доллар чинь өөрөө 100 мвт-ын-ын станц байхгүй юу.

Тэгэхээр бид нар бидний том дутагдал байна. Ерөөсөө байгаа боломжуудаа ерөөсөө ашиглахгүй байна. Жишээлбэл, сүү нийтдээ 20-оод сая бог сааж байгаа байх, 2 сая үхэр сааж байгаа байх. Энэ чинь өөрөө бас сүүг нь одоо 1 доллароор бодоод үзэхэд энэ 400 сая литр сүү чинь доор хаяж 200-300 сая доллар байхгүй юу. Бид энийг хаяна,

ашиглахгүй байна. Энэ чинь өөрөө 300 мвт-ын станц энийг ашиглахгүй. Тэгэхээр ийм нөхцөл байдал маань биднийг яах вэ энэ нөгөө байгалийн баялаг энэ алт, зэс, нүүрснээс орж байгаа мөнгөн дээр бэлэнчлэх сэтгэлгээ бий болгочихоод юмаа хийхээ больчихсон байна. Юм хийх сэтгэлгээгүй болно гэдэг чинь өөрсдөө бид нар хараат бус байдлыг бий болгоод байна шүү дээ. Би зүгээр улс төрчдөд бол ямар дутагдал байна вэ гэвэл энэ манай улс төрчдийн нэг дутагдал эрх мэдлээ, үүнийгээ яаж хадгалж үлдэх вэ гэдгээ тэргүүнд тавьчхаад байна.

Түүнээс улс орныхоо эрх ашгийг яаж бид нар ингээд хамгаалах вэ, үндэсний аюулгүй байдлаа яаж энийгээ хамгаалж явах юм бэ гэдэг дээр нэгдсэн бодлого бидэнд алга байна. Яриад байгаа болохоос бид нар ерөөсөө хийхгүй байна. Бидэнд боломж байгаад байна шүү дээ. Жишээлбэл, би бүүр жишээ авъя л даа. Бид нар 10 хэдэн жил, 20 жил утаа ярьсан. Бид нар шахмал түлшний үйлдвэр хийгээд л сэтгэл гаргаад л зориод л хийчихээр яасан тэр нь багассан, буурсан. Тэгэхээр бид нарт ерөөсөө сэтгэл дутаад байна. Яаж улс төрд үл тэсэж үлдэх вэ гэдгээ жоохон хэдүүлээ хойш нь тавья. Тэргүүн зэрэгт нь энэ улс орон чинь балрах гээд байна гэдгээ жоохон бодох хэрэгтэй болчихсон байна улс төрчид өө. Бидэнд жишээлбэл, нүүрс байна, занар байна, метан хий байна, нефть байна. Тэгсэн мөртөө эрчим хүчний хараат. Би 24 онд баларна шүү гэдгийг бол эрчим хүчний сайд байхдаа зөндөө хэлсэн.

Тийм учраас тэр үед энэ одоогийн ашиглалтад орж байгаа энэ батарей хуримтлуурын станц, ТЭЦ IV-ийг 100 мвт-аар өргөтгөж өгсөн. Ингээгүй

байсан бол өнөөдөр бүр гал алдаад суух байсан, бүр гал алдаад суух байсан. Ирэх ирэх жил бол Дорнодын 50 мвт-ын станц орох байх. Том станц хийчихье гэхээр мөнгөө гаргадаггүй. Иргэдийн цахилгааны төлбөрт 800 тэрбумыг гаргахад би Засгийн газрын хурал дээр Их Хурал дээр хэлж байсан. Энэ чинь 200 мега.../минут дуусав./

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Байж байгаарай. Ер нь энэ асуудлуудаа энэ Засгийн газар бас нэгдсэн байр сууриа оруулж ирээд энэ асуудлуудаа ярих нь зөв байх. Хэдүүлээ энэ асуудлыг зөвхөн хувь улс төрчийн байр суурь гэхээсээ илүү энэ Засгийн газар ер нь жаахан ажлаа хийх нь зөв шүү. Би үгээ хэлээдэхье. Ер нь өвөлжилтийн асуудал үнэхээр хүнд байна, хүндэрч байна. Цаг хугацааны хувьд бид нар өнөөдрийн хурал дээр, маргаашийн хурал дээр энэ асуудлыг өдөр тутам ярихгүй бол, энэ шийдэл гаргахгүй бол бид нар энд үг хэлээд нэмэргүй байна. Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун сайдыг өнгөрсөн 1 дэх өдөр Ардчилсан намын бүлэг дээр дуудаж энэ асуудлаа ярья. Ямар шийдэл, боломжууд байгаа юм бэ? Улсын онцгой комисс ямар шийдвэр гаргавал энэ асуудлын ард өвөлжилтийн энэ хүндэрсэн нөхцөлийн ард гарах юм бэ гээд санал солилцъё гээд дуудуулсан харамсалтай нь ирсэнгүй. Дээрээс нь Байнгын хороон дээр, Байгаль орчны байнгын хороон дээр бас Болорчулуун сайд ирээгүй. Энэ асуудлыг хэнтэй ярих гээд байгаа юм бэ. Өнөөдөр энэ Улсын онцгой комисстой энэ хөдөө аж ахуйн асуудал хариуцсан сайд энэ асуудлаа оруулаад нэгдсэн шийдвэр гаргуулах

ёстой хүн нь шүү дээ. Энэ асуудлаа ярьдаггүй, хэлэлцдэггүй ийм байдалтай л байна. Тэгэхээр энэ дээр ямар хариуцлага тооцох юм?

Ер нь цаашид энэ асуудал чинь хүндэрвэл хэн ер нь энэ асуудлыг хариуцах юм бэ? Энэ асуудал дээр ер нь бид нар тэр бум мод ярих биш энэ бас энэ асуулга дээрээ ч гэсэн үдээс хойших асуулга дээрээ ч гэсэн өвөлжилттэй өмнө нь ярилцсан асуудлууд ямар түвшинд шийдэл гарсан юм бас ярилцах зайлшгүй шаардлагатай л байна.

Хоёр дахь асуудал байна. Одоо чоно борооноор гэж өвөлжилт, шатахууны хомсдол, эрчим хүчний хязгаарлалтын тухай ярьж байх хоорондуур бас нэг асуудал орхигдоод байгаа. Энэ ногоон автобусны асуудал байгаа юм. Ногоон автобусны худалдан авах дээр Хянан шалгах түр хороо байгуулах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газарт яг хуулийн дагуу хүлээлгээд өгчихсөн байгаа. 25 гишүүн зурсан. Энэ 25 гишүүнийхээ бас энэ зурсан үүнийг хүндэтгээд бас Их Хурлын дарга маань энэ Түр хороог яаралтай байгуулмаар байна. Ер нь аливаа асуудлыг халуун сэргэг дээр нь авч хэлэлцэхгүй бол дандаа өнгөрсөн хойно нь, асуудал дууссан хойно нь, намжсан хойно нь бид бүхэн асуудлыг ярьдаг нь буруу.

Тэгэхээр энэ дээр ногоон автобусны Түр хороог Их Хурлын дарга минь яаралтай байгуулж өгөөч гэж хүсэж байна. Энэ дээр ч гэсэн бас эргээд л адилхан эрчим хүчний асуудал дээр бид нар төрийн мөнгөөр энэ худалдан авалт хийж байгаа энэ процессууд чинь ямар зүйл дээр алдаа гараад байгаа юм, тэр Төрийн болон албаны нууцын тухай

хуулиа бид нар яагаад зөв, буруу ашиглаад байгаа юм? Өнөөдөр ард түмний тэр бухимдаад байгаа тэр асуудалд нь бид нар хариулт өгч чадахгүй бол өнөөдөр бид нарын тэр Их Хурлын гишүүний үндсэн бүрэн эрх чинь энд болохгүй байна шүү дээ. Энэ хууль зөрчиж байгаа хуульд хяналт тавина гээд үндсэн үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хууль дээрээ, Их Хурлын тухай хуульд заачихсан, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд хүртэл заачихсан байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр яаралтай Түр хороог байгуулж өгөөч гэж даргаас хүсэж байна.

Г.Занданиатар: Одоо Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Баярлалаа дарга. Саяхан энэ Монголын ахмадын холбооны чуулган болсон. Энэ хуралд Монгол Улсын Ерөнхий сайд оролцоод ахмадуудад хандаж үг хэлж, тэдний санал бодлыг сонсоод, тодорхой амлалтууд өгсөн байгаа юм. Энэ дотор Ахмадын халамжийн тухай хууль, Ахмадын тухай хуулиудад тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд оруулна, шаардлагатай бол шинэчилж найруулна. Ингээд Монголын ахмадуудын нийгмийн хамгааллын асуудал, арчилгаа сувилгааны асуудал, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хуулиар зохицуулж шинэ шатад гаргах саналуудыг тавьсан. Үүнийг Ерөнхий сайд хүлээж авсан. Их Хуралд хандаж би тэр хуралдаанд бас оролцож байсан.

Улсын Их Хурал дээрээ энэ асуудлыг яриад, хууль боловсруулаад яаралтай хэлэлцээд, батлуулж авах арга хэмжээ аваач гэсний дагуу гэрээ байгуулаад яг энэ чиглэлээр Засгийн газартай хамтраад Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамтай хамтраад хууль боловсруулах ажилдаа орчихсон байж байгаа. Хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, заримыг нь шинэчлэх. Үүнийг хамтарч хийх, ажиллаач гэсэн хүсэлт би гишүүддээ тавьсан. 20 гаруй гишүүн гарын үсэг зураад ийм лобби бүлэг Улсын Их Хурал дотроо байгуулж ажиллая, зөвшөөрч байна, хэрэгтэй асуудал байна гээд санал нэгдээд гарын үсгээ зураад Их Хурлын даргад өгчихсөн байгаа. Та тэрийг өнөөдөр уншиж албан ёсоор танилцуулаад ийм лобби бүлэг байгуулагдлаа гэдгийг зарлаж өгөхийг хүсье.

Г.Занданиатар: Дашдондогийн Ганбат гишүүн. Энэ түр байж байгаарай. Энэ Нямаагийн Энхболд дарга чинь 15-ны чуулганд үг хэллээ, 14 цаг 11 минут үг хэлсэн юм байна. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая. Би энэ бас улс эх орны эрх ашгийн үүднээс л бид нарын хийх ёстой нэг ажлыг л ярих гээд байна л даа. Энэ 2 сарын 1-нээс өмнө бид бүхэн сонгуулийнхаа тойргийг ойлгомжтой болгох ёстой. Энэ ажлыг манай гишүүд яриад эхэлсэн бараг 10 гаруй хоногийн өмнө. Улсын Их Хурлын бас удирдлагаас ч гэсэн үүрэг чиглэл өгөөд, судалгаа хийгээд явж байгаа. Энэ дээр би бас хэдэн үг хэлье гэж бодож байна. Олон нийтийн сошиал орчинд ч гэсэн бас энэ талаар бас маргаан, мэтгэлцээн өрнөж байна. Энэ байдлуудаас дүгнээд үзэхэд ер нь бүсчилсэн хөгжил гэж бид нар байнга ярьдаг энэ асуудал маань энэ 33 жилийн хугацаанд ажил хэрэг болгож чадсангүй ээ. Энэ зүйл маань ерөөсөө бас энэ сонгуулийнхаас тойрогтоо байгаа юм шиг байна. Судалгаанууд ч түрүүчээсээ тэгж гарч байна гэж ойлгож байна.

Ер нь Манжийн дарлалд 300 жил байхдаа их жижиглэсэн Монгол Улсыг, дараа нь Коминтерны заавраар бараг 20 хэдэн аймаг болгоод 330 сум болгосон. Энэ маягаар Монгол Улсыг хөгжүүлэх энэ бодлого ингээд алдагдаад байна. Тухайн үедээ Монголчууд 1911-1924 онд л өөрөө өөрийгөө мэдэх эрхтэй байсан. Энэ үедээ Халх 4, шавь 5 дахь нь гээд, баруун хязгаар гээд хуваарилалтаа хийж нэлээн эмх цэгцдээ ороод хөгжлийнхөө зам руу орж байсан.

Тэгэхээр бид бүхэн сонгуулийнхаа тойргийг томсгоод бүсчилсэн хөгжил та бүхний яриад байгаа, бид нар бүгдээрээ л ярьдаг шүү дээ говь, хангайг хослуулаад ингэхгүй бол болохгүй нь. Энэ 330 сум 21 аймгаас чинь болоод энэ жижиглэснээс чинь болоод ерөөсөө хүн нь ч цус нь ойртсон, мал нь ч давжаарсан ийм бүтэцтэй 70, 80 жил явлаа. Одоо үүнийг бид нар өөрчлөх цаг нь болсон. Ер нь манай нэрт нийтлэлч Баабар гуай ч гэсэн бас түүхийг яг үнэн, зөвөөр нь бичдэг хүн л дээ тэгээд хараад хийж байгаа. Энэ Их Хурлын зориг нь хүрэхгүй дээ.

Ер нь манай Ардчилсан намын үе үеийн ардчилагчид бол байнга л энийг хийчихье гэж ярьдаг. Бид нар их өөрсдийнхөө эрх ашгийг хүртэл болгодоггүй. Хэрэв та нар одоо энэ зүйлийг хийх гэж байгаа бол бас манай нам ч арай яриагүй байна. Би хувь хүнийхээ байр суурийг илэрхийлэхэд бол энийг хийе. Тэгэхгүй бол арай хэтэрч байна шүү дээ. Яг дундад зууны үе шиг болчихсон. Тэр вангийн дүүрэг, тэр баяны харьяа газар, тэрний хамжлага, тэр Ерөнхийлөгчийн хулгайчийн нөөцийнхөн гэсэн ийм нэрсийг нэг нэгэндээ шидлээд л ингээд л улс орон хөгжихгүй. Хүмүүс нэг үеэ бодвол

ойлгодог болчихжээ нийгэм бол. Байнга 90, 100 жилээ бид нар тэмдэглээд л шүү дээ. Нөгөө л модон жорлонтойгоо. Энэ хэдэн жуулчдыг авсан ч гэсэн ичгэвтэр байна л даа. Эд нар бол Улаанбаатарыг үзэж хараад байх юм юу ч алга. Өнөөдөр Улаанбаатар Алтан тэвшний хөндий биш, аз жаргалтай Алтан тэвшний хөндий биш үхлийн хөндий болсон. Хоёр хүний нэг нь энд байж байна. Бүсчилсэн олигтойхон шиг бүсийн төв байгуулаад, энэ зуд ч гэсэн, энэ бензин тос ч гэсэн, энэ бүх юм чинь энэ ямар нэгэн хэмжээгээр энэ юмтай холбоотой байна. Одоо энэ судалгаа юм хумаа хараад би бас та бүхэнд эргэлзээд байгаа.

Ингэж ингэж байгаад л нөгөө Манжийн үеийнхээ юман дээр л бууна даа. Нөгөө Коминтерныхоо үеийнхээ эргээд л тэгээд л Ганбат бетон тараадаг, тэр боов тараадаг үгүй тэгээд бетоноос ч олигтой эд юм тараадаг хүн ч байхгүй боллоо л доо хэрэгтэй юм. Одоо энэ юм чинь дуусвал яасан юм бэ? Үнэхээр бодлогоо дэмждэг, бодлого ярьдаг, улс орныхоо асуудлыг ишиддэг ийм Улсын Их Хурал баймаар байна. Тэгэхгүй бол тэр хавийн хот айлын асуудлыг ярих гээд л санал гуйгаад л явж байдаг юмаа больё. Тэнд чинь багийн хурал нь байна, аймгийн хурал нь байна, аймгийн дарга нь байна, сумынх нь хурал нь байна. Шат шатдаа юмаа ишиддэг больё. Улс орны асуудал орхигдож байна. Энэ асуудлаа одоо.../минут дуусав./

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн ирээгүй байна уу? Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Яг өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай шууд холбогдсон асуудал байхгүй байна.

Гэхдээ энэ цаг үеийн асуудал, өвөлжилтийн асуудлаар Болорчулуун сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд холбогдсон асуудлуудаар холбогдох Байнгын хороотойгоо хэлэлцээд ирэх долоо хоногт тэр Их Хурлаас дэмжлэг үзүүлэх яаралтай шийдэх арга хэмжээнүүдэд шуурхайлаад яв. Хоёрдугаарт энэ Даваасүрэн гишүүн, Ганибал гишүүдийн гаргасан санал.

Нямаагийн Энхболд гишүүн ахмадын холбоотой асуудал, Ахмадын холбооноос ахмадын эрхийн асуудлаар бичиг конвенц ирсэн. Тэр Хууль зүйн байнгын хороон дээр цохогдоод явж байгаа ахмадын эрхийн конвенцын тодорхой заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлууд. Хууль зүйн байнгын хороо хойшлуулсан. Танай юуг бол одоо зарлачихна. Тийм, бүлгийг. Ганбат гишүүний гаргасан саналын хувьд хуулиараа 2 сарын 1-ний дотор шийдэх ёстой. Ингээд нам, бүлгүүд саналаа өгөөд илэрхийлээд ойрын хугацаанд намын бүлгүүд, Төрийн байгуулалтын байнгын хороо энэ асуудлыг хэлэлцэх ёстой. Ирэх долоо хоногоос ер нь хэлэлцээд нэг тийшээ шийдсэн нь дээр байх. Оньсого таалгаад яах вэ ард түмэнд. Ногоон автобустай холбоотой асуудал хянан шалгалтын түр хороог Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу Байнгын хороо хэлэлцэж шийдвэрлэнэ. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тодорхой чиглэлээр, эс үгүй бол тодорхой асуудлыг суулгах, хянан шалгах Түр ороод Байнгын хороон дээрээ хэлэлцээд ингээд л шийдвэрлээд явдаг. Тэгэхдээ Улсын Их Хурлын дарга тэнд байгуулдаг, байгуулахгүй байх, гишүүдийн 4-ний 1-ээс дээш буюу 19-өөс дээш гишүүн санаачилсан бол ингээд л

хойшлуулахгүйгээр байгуулаад Байнгын хороогоор хэлэлцээд явах ёстой. Тэр дээгээрээ явах байх. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Хуулийн төслүүдийг хэлэлцэн батална.

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу баасан гаргийн 10 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батална гэж заасан. Адьясүрэн гишүүнээ энэ чинь энэ Өвөрхангайн зам, Баянхонгорын зам, баруун чиглэлийн замуудыг засах агуулгатай юм уу Бямбацогт сайд аа? Зүүн талынх ч гэсэн орж байгаа байх. Тогтохоо даргаа хүрчихсэн байна. Бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт. Энэ төхөөрөмж ажиллахгүй байна шүү. Минийх харин төхөөрөмж ажиллахгүй байна. Шалгалт хийсэн нь боллоо.

Ингээд Дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нийт гишүүдийн олонхоор батална. Санал хураалт явуулъя.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя

гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2.Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсьё.

Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалд орно.

10.45 цаг

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд, бусад Даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим

бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээ цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 23 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар тусгасан зарим заалтыг төслийн 1 дүгээр зүйлд нэмж тусгах техникийн саналыг тус Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлд тусгуулах санал гаргасан. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжийн засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Инновац, цахим бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцъя. Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мөнхжаргалын Мөнхбаатар Монголын банкны холбооны

дэргэдэх Хуульчдын мэргэжлийн зөвлөлийн дарга, Чадраабалын Баянжаргал Монголын Нотариатчидын танхимын Ерөнхийлөгч, Мандахын Сайнбилиг Монголын мэдээллийн технологийн захирлуудын холбооны ерөнхийлөгч, Жамсрангийн Батжаргал Монголын даатгалын холбооны гүйцэтгэх захирал, Мягмарцэрэнгийн Бямбасүрэн Монголын финтекийн холбооны гүйцэтгэх захирал.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Энэ эцсийн хэлэлцүүлэг байгаа. Асуулт алга байна. Одоо санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Ингээд цахим, 4 саналаар санал хураалт явуулна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд

шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.”. Санал гаргасан Инновац, цахим бодлогын байнгын хороо.

Энэ чинь өгсөн чиглэлийн дагуу. Тэмүүлэн гишүүн хаачсан юм? Энэ нөгөө яриад байсан санал нь. Хөдөө яваа юу? Туссан юм байгаа биз дээ Чинбүрэн гишүүнээ, Тэмүүлэн гишүүний санал нь туссан уу? Санал хураалт.

70.2 хувиар санал дэмжигдлээ.

Гааль, татварын мэдээллийн төвийн, гааль, татвар, санхүүгийн мэдээллийн төвийн мэдээлэл чинь Хувь хүний мэдээллийн нууцын тухай хуулиар нийт дата нь ашиглагдаж болохгүй байгааг л, ер нь цаашидаа үндэсний дата товчоо байгуулж энэ дата төвийн дэргэд байдаг юм уу тэр датаг нэгтгэх, хиймэл оюун ухаан тэгээд л датагүйгээр юу ч ажиллахгүй шүү дээ. Дата чинь түүхий эд нь, бааз нь. Тэгтэл бид нар датагаа ашиглаж чадахгүй суугаад байдаг.

2. “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

1.Төслийн 1, 2 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах

тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ-т даалгасугай:

1/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдөл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалт 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4/уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих, дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршлага, ноу-хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршлага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн

түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх;

6/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо Э.Батшугар-д даалгасугай.”. Санал гаргасан Инновац, цахим бодлогын байнгын хороо. Санал хураалт, санал хураалт.

74.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараа нь Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан Инновац, цахим бодлогын байнгын хороо санал хураалт.

72.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авч болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан Инновац, цахим бодлогын байнгын хороо. Санал хураалт.

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Ажлын хэсгийн ахлагч протоколд бүртгүүлэх санал гэж байхгүй л дээ. Эцсийн найруулга дээр анхаараад, эцсийн найруулга дээр Чинбүрэн гишүүн энэ протоколд тусгах юмнуудаа Мягмар даргаа тэгээд тэрийгээ хяналтад оруулаад бүртгүүл, протоколд тусгуулах. Дараагийн асуудалд орно. Онцгой албан татварын тухай хуульд, ажлын хэсэгт баярлалаа. Эцэслэн батлах чинь өнөөдөртөө батаж амжихгүй тээ?

10.56 цаг

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцдэг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа танилцуулна.

Таны хууль хэлэлцэх гэж байхад танай намынхан бүгдээрээ гараад явчихдаг яаж байгаа юм болоо?

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй хэмээн

тунхагласан Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2016 онд бүх улс орнуудад хандан таргалалт, чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэр нэмсэн ундаанд татвар ноогдуулах хуулийн төсөл өргөн барьж батлуулахыг бүх орнуудад уриалсан байна.

Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 2100 сурагчдын амтат ус, ундааны хэрэглээ тэдний таргалалтыг судалж үзэхэд 14 хувь нь илүүдэл жин, таргалалттай. Өдөр ууж буй шингэний 1/3-2/3 нь амтат ус, ундаа, цай эзэлж байна гэжээ.

2010 онд 4 хувь байсан илүүдэл жин таргалалт 17 онд 28 хувь болж 7 дахин нэмэгдсэн үзүүлэлт байна. Мөн 14-18 насныхны 54.9 хувь нь сургуулийн ойр орчмоос амтат ус, ундаа худалдаж авдаг гэж хариулжээ. Манай улсад артерийн даралт ихсэх өвчин насанд хүрсэн 4 хүн тутмын гуравт тохиолдож байгаа нь маш их сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна. Хөдөлгөөний хомсдол, таргалалт, стресс, чихрийн шижин ч мөн зүрх судасны эмгэг үүсэх хүчин зүйлүүд болсон байна.

Иймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын уриалгыг дэмжиж Америкийн Нэгдсэн Улсын 8 муж, Австрали, Мексик, Чили, Дани, Финлянд, Норвег зэрэг дэлхийн 100 гаруй улс орон энэ хуулийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ хуулийг хэрэгжүүлснээр 1 хүнд ноогдох чихэрлэг ундааны хэрэглээг 22.8 литрээр бууруулах боломжтой гэсэн тооцоолол гарч байна. Мөн үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрлэж буй ундааны сахрыг багасгах гаднаас оруулж ирэх хувийг бууруулах, түүнийг орлуулах цэвэр ус, эрүүл хүнс, жимс ногооны хэрэглээг дэмжих, нөгөө талаар

хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургуулийн орчинд эрүүл хүнс, ус ундаа борлуулах зэрэгт чиглэсэн боловсролын интервенцийг дэмжихэд чиглэсэн юм. Татварын орлогыг нэмэгдүүлэхдээ биш үйлдвэрлэлийг шууд хязгаарладаг гэдэг талаас нь харахгүй эрүүл мэндийг дэмжих хууль гэдэг талаас нь харж хандах хэрэгтэй байна.

2012 оны өрхийн чихэрлэг ундааны зардлыг 15 онтой харьцуулахад 41 хувиар өссөн. Тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хэрэглэгчийн эрүүл мэндэд ноцтой үр дагаварт хүрэхийг сэрэмжлүүлж байгаа баримт юм.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Уг хуулийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагчид хүн амын дунд чихэрлэг, хэт чихэрлэг ундааны хэрэглээ

ихсэж байгаатай холбогдуулан хэт таргалалтаас урьдчилан сэргийлэх чихрийн шижинг бууруулах зорилгоор чихэрлэг ундааны онцгой албан татварыг нэмэхээр тусгасан бөгөөд ингэснээр үйлдвэрлэж буй ундааны чихэрлэгийн хэмжээг багасгах, импортоор оруулж ирэх хувийг бууруулах, түүнийг орлох эрүүл хүнс болон жимс, ногооны хэрэглээг дэмжих, хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсролыг олгох үүднээс Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор энэ хууль батлагдсанаар хэрэглээ сөрөг нөлөөлөл тодорхой хэмжээгээр буурах боловч цаашид эрүүл хооллолт чихэрлэг ундааны зохистой хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэх талаар нийгмийн эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хамтарч ажиллах нь зүйтэй хэмээнэ гэсэн саналыг хэлсэн болно.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Энэ Бат-Эрдэнэ гишүүн, Анужин гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Пүрэвдагвын Батхишиг Улсын Их Хурлын дэд даргын зөвлөх, Мандахын Ундрам Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн багш.

Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууна.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бид нар маш чухал хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдэх гэж байна. Тэгэхээр эмэгтэй гишүүд бид энэ иргэдийнхээ тэр дундаа энэ хүүхэд залуучуудынхаа эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэ чихрийн агууламж орсон энэ хийжүүлсэн болон хийжүүлээгүй амтат ундаанд онцгой албан татвар ноогдуулах энэ хуулийн төсөл бас боловсруулсан байгаа.

Тэгэхээр энэ чихрийн хэрэглээ хэтэрч, энэ хүн амын өвчлөл суурь шалтгаан болж байгааг эрүүл мэндийн байгууллага, судлаачид маш сайн тогтоогоод байгаа. Тэгэхээр энэ судалгаагаар сургуулийн сурагчдын 80.9 хувь нь чихэртэй ундааг долоо хоногт 1-ээс дээш удаа хэрэглэдэг эрүүл бус хүнсний хэрэглээ түгээмэл байгааг бас илтгэж байгаа.

Тэгэхээр чихэрлэг ундаа ямар ч шимт бодисгүй болж өндөр илчлэг өгснөөр энэ зүрх судасны өвчлөл,

таргалалт, шүдний цоорол, чихрийн шижин зэрэг энэ халдварт бус өвчний гол шалтгаан болж байгаа. Жишээ нь манай улсын 18 нас хүртэлх хүүхдүүдийн 84-96 хувь нь шүд цоорсон буюу энэ 15 хүн тутмын 1 нь чихрийн шижинтэй байна гэсэн ийм судалгаа байгаад энэ цаг үед бас энэ чухал хуулийг хэлэлцэж байна.

Тийм учраас энэ та бүхнийг бас хуулийн төслийг дэмжиж өгөхийг уриалж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Та бүхэн маань мэдэж байгаа хуучин бид нар усыг хар ус гэж нэрлэдэг байсан бол одоо хамгийн эрүүл ундаа гэж үздэг. Ямар ч үйл явдал дээр ширээн дээр ус байдаггүй газар гэж байхгүй болчихлоо. Харамсалтай нь үр хүүхдийн маань хувьд нялх балчир байгаа учраас амттан чихэр жимс рүү явдаг нь өөрөө хүүхдийн зан юм. Үүнээс эрүүл мэндэд нь хор уршигтай талыг нь бас татгалзуулах, өгөхгүй байх энэ асуудлыг томчууд эцэг эхчүүд бид хариуцах учиртай.

Сая Одонтуяа даргын хийсэн танилцуулгад тов тодорхой байлаа. Энэ чихэртэй ундааны улмаас хүүхдүүдийн маань таргалалт, илүүдэл жин хэрээс хэтэрсэн эрүүл мэндийнх нь асуудалд бодит хор хохирол учрах ийм нөхцөл байдал үүссэнийг хэлж байна. Энэ бол эрдэмтэн, судлаачид батлаад нотолсон зүйл учраас энэ талаар ярих зүйл алга. Хамгийн гол нь энэ хуулийн төслийг Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд санаачлаад ингээд явахаар манай үйлдвэрлэгчид нэлээн эмзэг хандаж байгаа. Одоо бас зарим улс төрчийн

зүгээс ч гэсэн энэ татварын асуудалд гишүүд оролцох хэрэггүй гэсэн ийм зүйлийг яриад байгаа юм.

Бид нар ер нь татварын асуудал яриагүй байгаа шүү дээ. Үйлдвэрлэгчид болон импортлогч оруулж ирж байгаа үйлдвэрлэж байгаа ундааныхаа чихрийн агууламжийг үр хүүхдэдээ, үр хүүхдээ хордуулахгүй байх түвшинд л хийгээд, бүтээгээд оруулаад ир. Ийм байх юм бол татвар нэмэх тухай асуудал ерөөсөө яригдахгүй. Энэ татварын асуудал биш, үр хүүхдүүдийн маань ирээдүйн эрүүл мэндийн асуудал юм байгаа юм.

Тийм учраас энэ хуулийн төслийг ингээд дэмжих учиртай. Илүүдэл жин өөрөө өвчлөлийн эрсдэл, таргалалт бол аль нэг өвчний бодит аюул гэдгийг бид бүгд мэднэ. Өнөөдөр та бүхэн статистик мэдээлэл сонссон 18 хүртэлх насны хүүхдүүдийн маань наяд хувь нь шүд цоорох өвчтэй байна илүүд илүүдэл жин, таргалалтаас гадна. Үүнийг манай эрдэмтэн, судлаачид мэргэжлийн хүмүүс энэ чихэрлэг ундааны чихэр жимсний хэрэглээ хэрээс хэтэрсэнтэй холбоотой гэж ингэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ сургуулийн ойр худалдаад байгаа чихрийн агууламж өндөртэй хийжүүлсэн ундааны хэрэглээг хүүхдүүддээ аль болох бага өгөх үүднээс бид нар энэ хуулийн төслийг санаачилсан.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдээ бусад эмэгтэй гишүүдийнхээ нэгэн адил энэ хуулийн төслийг татварын асуудал биш, хүүхдийнхээ эрүүл мэндийн асуудалд санаа тавьж байгаа ийм хууль гэж ойлгож дэмжихийг та бүхнээсээ хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сарангэрэл гишүүн үг хэллээ тийм ээ. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ хуулийн төслийг бол зарчмыг нь дэмжиж байгаа юм. Би зүгээр асуулт асуухгүй, санал хэлье гэж бодож байна. 2016 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудад энэ чихэрлэг ундаанд онцгой татвар ноогдуулах зөвлөмжийг гаргасан байдаг. Энэ зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтарч, хөрөнгө санхүүгийн асуудлыг ишийдэж өгч анагаахын шинжлэх ухааны чихэрлэг ундаанд татвар ноогдуулах тооцооллын судалгаа бол хийлгэж нийт бас иргэдийн дунд чихэрлэг ундаа, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ ямар түвшинд байна вэ гэдгийг бас судалгаа бол хийлгэсэн байдаг.

Тэгэхээр энэ судалгааны дүнгээс харахад бол манай насанд хүрэгчдийн дунд ч тэр, хүүхдүүдийн дунд ч тэр чихэрлэг ундааны хэрэглээ асар их, бас өндөр байна гэсэн ийм судалгаа гарсан байдаг. Насанд хүрэгчдийн энэ 15-69 насны хүн амын маань 31 хувь нь илүүдэл жинтэй гэсэн ийм судалгаа гарсан байдаг. Энэ илүүдэл жин нас ахих тусам бас нэмэгдэж байдаг ийм судалгаа гарсан юм байна лээ. 25-34 насныхны илүүдэл жин 15-24 насныхны илүүдэл жингээс 2.5 дахин бас илүү өндөр илүү байна гэсэн ийм бас судалгаагаар гарсан байдаг. 5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд 11 хувь, 6-10 насны хүүхдүүдийн дунд илүүдэл жин 22.2 хувь, 12-18 насны өсвөр насны хүүхдүүдийн дунд илүүдэл жин 18 хувьтай байна гэсэн. Үүний гол үндэс нь ерөөсөө л энэ чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн, чихэрлэг ундааны бас

өндөр хэрэглээтэй холбоотой байна гэсэн.

Тийм учраас бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан энэ онцгой чихэрлэг ундаанд онцгой татвар ноогдуулах энэ зөвлөмжийг бас Монгол улс хэрэгжүүлэх нь зүйтэй гэж бол үзэж байгаа юм. Судалгаагаар бол дэлхийн 85 гаруй улс орон бол энэ чихэрлэг ундаандаа татвар ноогдуулсан байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас бол хамгийн багадаа чихэрлэг ундаанд нь 20 хувийн татвар ноогдуулахыг бас улс орнуудад зөвлөсөн байдаг. Хүүхдүүдийн дунд өнгөрсөн жил бид эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг явуулсан. Энэ эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн маань 67 хувь нь хувь нь шүдний цооролттой гэсэн ийм бас статистик дүн мэдээ гарсан. Энэ бол үндсэндээ явж явж энэ чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн, чихэрлэг ундааны бас хэрэглээтэй байна гэдэгтэй шууд холбоотой байгаад байгаа юм. Насанд хүрэгчдийн дунд зонхилон тохиолдох өвчин бол нэгдүгээрт энэ зүрх судасны өвчин байгаа юм. Энэ зүрх судасны өвчний чинь гол бас л асуудал нь энэ илүүдэл жин, таргалалт. Энэ илүү илүүдэл жин, таргалалтын чинь гол үндэс нь ерөөсөө энэ хүнсний бүтээгдэхүүн, чихэрлэг ундаа, хүнсний чихэрлэг хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой байна гэж. Чихрийн шижин өвчин бол манай улсад сүүлд маш их нэмэгдэж байна. Энэ чихрийн шижинг дэлхий нийтээрээ чимээгүй тахал гэж бас нэрлэж, үүнээс бас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг улс орнуудад бол уриалаад байгаа юм

Тийм учраас бол хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд тохиолдож байгаа энэ өвчлөлийн чинь гол суурь нь

энэ илүүдэл жин, таргалалт, хөдөлгөөний хомсдол, тэгээд дээр нь хүнсний бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой гэсэн ийм асуудлууд байгаа юм.

Тийм учраас бол би энэ Одонтуяа гишүүн нарын санаачилсан чихэрлэг ундаанд бас онцгой татвар ноогдуулах энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа юм. Гишүүдийг бас дэмжиж өгөхийг бас та бүхнээсээ хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бидний санаачлан оруулж ирж байгаа энэ хуулийн төсөл цаг хугацааны хувьд бүүр алдаад байгаа юм. Одоогоос 7 жилийн өмнө л Эрүүл мэндийн яамнаас бас сургуулиуд, олон улсын байгууллагуудаас танайх энэ чихэрлэг ундаандаа иуурхай арга хэмжээ авахгүй бол энэ чинь бүүр сүүлдээ үндэсний аюулгүй байдлын түвшний асуудал болох вий дээ гэж ярьж байсан. Би яг Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллаж байх үед багш нараас, сурагчдаас, эцэг эхээс гээд бараг 1000 гаруй хүний гарын үсэгтэй бичиг хүртэл ирж байсан. Сургуулийн орчинд энэ өндөр чихэрлэгийн агууламж өндөртэй ундаа, жигнэмэг, гурилан бүтээгдэхүүн зарахгүй байх, эсвэл хэмжээнд нь байх дээр Мэргэжлийн хяналтын хяналт тавихгүй болохоо байлаа, хүүхдийн таргалалт, таргалалтаар дамжаад шүдний өвчлөл бүүр байх ёстой хэмжээнээс 2, 3 дахин их боллоо гээд ярьж байсан. Бид нар хуульд өөрчлөлт оруулаад орж ирсэн боловч Их Хурлын босго давж чадаагүй.

Гэтэл үүнээс хойш яасан 5 жилийн дотор л гэхэд энэ өвчлөл өөрөө

дахиад 2 дахин нэмэгдчихсэн. Сүүлд бас эмч нарын ярьж байгаагаар хүүхдийн энэ яс маш хэврэг болчихлоо, жоохон шургаж унаад л хөл нь хугарчихсан, гар нь хугарчихсан гээд гэмтлийн эмнэлгээр хүүхэд дүүрэн болж байна гээд жишээ нь ярьж байгаа. Энэ бүхэн нь юу юм гэхээр бид нар хүнсний аюулгүй байдлаа алдчихсан нэгт.

Хоёрт тухайн үед нь цаг хугацаанд нь арга хэмжээ авч чадахгүйгээс болоод ингээд бүүр тоо, статистикаа алдаад маш олон хүүхдүүд маань дээрээс нь том хүмүүс ч гэсэн өвчин, таргалалтыг дамжаад бүх өвчний үр бол таргалалт гэдэг бүх төрлийн өвчин, хорт хавдар тээ. Тэгээд л сая хэлж байна яс нь хэврэг болж байгаа, шүдний өвчин гэх мэтчилэнгээс асуудал үүсгэж байна л даа.

Тийм учраас бид нар энэ ялангуяа сахрын агууламж өндөртэй чихэрлэг ундаанд ноогдуулах татварыг шуурхай авч хэрэгжүүлэх нь хэрэгтэй байгаа юм. Гэхдээ энэ бүх чихэрлэг ундаанд л татвар ноогдуулна гэсэн үг биш шүү дээ. Бусад улс орон жишээ нь Англид юм уу 3 шатлалтай байдаг. 5 гр-ын дотрын буюу сахрын агууламж нь хэвийн хэмжээндээ байвал 0 буюу татваргүй, яг л нормал, хэвийн гэж үзэж байгаа. Харин 5 гр-аас дээш, 8 гр, 10 гр болчихвол тэр нь шатлалаараа татвар нь өндөр болоод явчихдаг. Энэ бол дэлхийн сая Чинзориг сайд ч хэлж байна бараг 85 улс оронд үүнийг хэрэгжүүлээд үр дүнд хүрээд, иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалаад явж байгаа.

Тэгэхээр энэ бол татварын асуудал биш. Хүнсний аюулгүй байдал, иргэдийн маань, ялангуяа хүүхэд багачуудын маань эрүүл мэндтэй

холбоотой тулгамдсан чухал асуудал учраас Улсын Их Хурлын гишүүд маань энэ хуулийг хэлэлцэхийг дэмжээд бас цаг алдалгүй батлах хэрэгтэй байна. Энэ татвар нэмлээ гээд энэ чихэрлэг ундаа үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжүүд дээр, нуруун дээр нь том дарамт болох юм огт байхгүй, шатлалтай байна, хуулийн хүрээнд байна.

Дээрээс нь Монгол Улс эрүүл хүнс, яг энэ чихэрлэг ундаа хийхийн оронд зүгээр ус юм уу, эсвэл жимсний ундаа тэр нь чихэрлэг багатай 5 гр-ынхаа хэмжээнд байж байдаг ч гэдэг юм уу ингээд олон улсын стандартын дагуу, хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу ундаа үйлдвэрлээд явчихвал ямар ч асуудал байхгүй. Тийм учраас энэ татвар ноогдуулах тухай асуудлыг Улсын Их Хурал бас цаг алдалгүй хэлэлцээд явчих хэрэгтэй байна. Үүнийг ч гэсэн манай олон нийт, иргэд хүлээж байгаа. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд маань дэмжинэ гэдэгт би итгэлтэй байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Үг хэллээ, дэмжиж үг хэлж байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Үнэхээр Одонтуяа гишүүн болон бидний өргөн барьсан энэ хуулийн төслийг энэ цаг үед хэлэлцэж байгаад, мөн эцэслэн батлагдаасай гэдэг бас хүсэлтийг тавих гэсэн юм. Яагаад гэвэл шинэ жилийн баяр ойртож байна. Тун удахгүй ижий аав нар үр хүүхдүүддээ, ач зээ нартаа бас бэлэг бэлдээд бид нар бүгдээрээ л завгүй явна. Бэлэг сонгох энэ мөчид бас эцэг эхчүүддээ бас уриалга хийлгэх ёстой байх гэж бодож байна.

Яагаад бид онцгой албан татвар дээр бас тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах ёстой, сахрын агууламж өндөртэй бүтээгдэхүүнийг бас шат дараалсан татварыг нэмье гэдэг ийм санал гаргаж байна вэ гэвэл хүүхдүүдийнхээ ирээдүйн эрүүл мэндийн төлөө бас анхаарч байгаагийн хамгийн том илрэл.

Ер нь бусад улс орнууд энэ сахрын хэрэглээг дайнтай, дайн мэтээр үздэг. Өөрөөр хэлэх юм бол сахартай тэр хэмжээнд ажилладаг гэсэн үг, тэмцдэг гэсэн үг. Яагаад ингэж тэмцэх ёстой юм бэ гэвэл сая манай гишүүд бүгдээрээ л статистик мэдээлэл, тоон мэдээлэл хэллээ. Насанд хүрсэн хүн өдөрт 25 гр сахар хэрэглэх ёстой байдаг бол зөвхөн бид нарын хүүхдийн баяраар шинэ жилээр хүүхдүүддээ бэлдэж өгдөг 1 уут сахар бэлгийн хэмжээ гэхэд түүнээс хэд дахин өндөр байгаад бид хүүхдүүдийнхээ төлөө, ирээдүйнхээ төлөө их зүйл хийх ёстой гэдгийг бас анхааруулж байгаа юм.

Энэ онцгой албан татварын хууль Франц болон Их Британи, Мексик улсууд маш өндөр хэмжээнд хууль болоод хэрэгжиж байдаг. Доод тал нь 5-10 хувийн татвар аваад байх жишээтэй. Энэ бол зөвхөн үйлдвэрлэгчид болон худалдаачидтай бид нар тэмцэж байгаа асуудал биш юм. Бид бүгдээрээ хамтдаа үр хүүхдүүдийнхээ ирээдүйд төлөө ажиллах ёстой гэдгийг бас онцгойлон хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Өнөөдөр манайд газтай ундаа гэхэд 1.5-2 литрийн савлагаатай зарагдаж байх жишээтэй. Энэ бол үнэхээр бид дараагийн шатын арга хэмжээ авахгүй бол хүүхдүүд маань ясны сийрэгжилт болон бусад өвчнөөр өвдөх бүрэн эрсдэл дунд байгаа юм. Тийм учраас бидний

өргөн барьсан энэ хуулийг яаралтай хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Нөгөө талаар бас Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль яг хэлэлцэгдэж бас бид нар бас батлах гээд ажиллаж байна. Энэ цаг мөчид юуг хэлэхийг хүсэж байна вэ гэвэл зөвхөн онцгой, ноцтой байдлын үед хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагууд маань олон нийтээ уриалж нөлөөлөхөөс илүүтэйгээр яг ийм цаг мөчид бас иргэд олон нийт рүүгээ хандсан уриалга бүхий мессежүүдийг промо юу байдаг юм, тэр бүхэн дээр бас анхаарч ажиллаж өгөөч гэдэг хүсэлтийг бас тавих нь зүйтэй байх гэж бодож байна. Энэ бүхэн бол бид бүгдийн ирээдүйн төлөө хийгдэж байгаа ажил шүү гэдгийг бас хэлье. Чуулганы энэ өдөрт бас гишүүд маань энэ хуулийг дэмжээсэй. Таны үр хүүхдүүдийн төлөө, ач зээ нарын төлөө энэ хууль өргөн баригдсан байгаа. Яагаад гэвэл бидний хүүхдүүд эрүүл, аюулгүй орчинд өсөх ёстой гэдэг энэ үзэл баримтлалын хувьд, хүрээнд бид нар хууль, эрх зүйн орчноо баталгаажуулж байгаа бол хамгийн чухал зүйл бол бидний хүүхдүүдийн эрүүл мэнд шүү. Үүн дээр анхаарч саналаа өгөөрэй гэдэг зүйлийг хэлье. Баярлалаа.

Г.Занданишатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ:

Их баярлалаа. Гишүүдийнхээ санаачилсан энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ ер нь Монгол үндэстний, Монгол хүн амын хүүхэд залуучуудын өмнө тулгамдаад байгаа эрүүл мэндийн асуудал, бие бялдрын хөгжлийн асуудал, хүнсний аюулгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ гээд энэ олон асуудлыг цогцоор нь авч үзэх ийм зайлиггүй шаардлага байна гэж ингэж үздэг. Энэ талаас нь

манай Их Хурал бол яаралтай ажиллах хэрэгтэй байна. Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг баталлаа. Энэ мөн энэ бүрэлдэхүүн хэсэгт нь орно. Хамгийн гол нь салбар дундын уялдаа хэрхэн хангагдаж байна вэ гэдэг дээр онцгой анхаарах ёстой. Бид удахгүй Биеийн тамир спортын хуулийн төслийг шинэчлэл найруулгаар оруулж ирэхээр төлөвлөж байна. Нэлээн сайн ажиллачихсан байгаа. Үүн дээр та бүхнийгээ анхаарал хандуулахыг би хүсэж байгаа юм.

Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ энэ бол үнэхээр тулгамдсан асуудал мөн үү гэвэл мөн. Нөгөө талд нь хөдөлгөөний дутагдал, үүнээс шалтгаалсан өвчин эмгэг, хүний эрүүл мэндийн байдал, дархлаа, олон хүчин зүйлүүд бодитойгоор аюулын харанга дэлдэж байгаа. Үүнийг бид нар анхаарахгүй бол болохгүй байна.

Яагаад ийм асуудлууд гардаг вэ гэхээр зэрэг бид нар хуучин тогтолцооны үеэсээ эхлээд дэлхийн бусад улс орнуудад, хөгжингүй улс орнуудад биеийн тамир спорт хөгждөг тэр ерөнхий жишиг загварыг нь бид нар хайхрахгүй орхичихсон. Зөвхөн их спортын тамирчдыг бол үзэл суртлын гол зэвсэг хэлбэрээр зөвхөн амжилт л гарга, бусад нь чамд хамаагүй гэдэг ийм байдлаар хандаад, нийтийн биеийн тамирын асуудлыг бол тийм компаничилсан хэлбэрээр явуулах гэж оролдоод тэгээд мухардалд хүрчихсэн. Өөртэй үр дүнд хүрээгүй.

Гэтэл бусад улс орнуудад биеийн тамир спорт бол пирамидын ийм тогтолцоотой. Тэр пирамидын орой дээр байж байгаа үлэмж амжилт гаргасан тэр тамирчид бол спортын одууд гэж ярьдаг. Тэр спортын одууд бол үзүүлсэн

амжилтаараа төдийгүй, ур чадвараараа төдийгүй бусад бүхий л талаараа нийгэмд энэ хүүхэд, залуучуудад сайны үлгэр манлайлалтай. Тэр сайны үлгэр манлайлалтай тамирчдаа харж, тэр пирамидын суурийг бүрдүүлж байгаа үй олон хүмүүс өдөр тутам өөрийнхөө эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв амьдралын энэ дадал хэвилийн төлөө биеийн тамир спортоор байнга хичээллэж байдаг. Энэ тогтолцоог л бид нар хайхарч үзээгүй орхичихсон. Өөртөө үр дүнд хүрээгүй.

Тэгэхээр зэрэг энэ тогтолцоог бид нар бий болгоход бүх талаар анхаарах, энэ биеийн тамир, спортын заал танхим, энэ орчны эрүүл ахуйн стандартыг бид нар бүрдүүлэх хэрэгтэй байгаа юм. Ямар ч стандарт байхгүй ийм заал, танхимуудыг бий болгосноор энэ спортоор, биеийн тамираар хичээллэж байгаа залуучууд маш залуу насандаа үеэ солиулах ийм нөхцөл байдал руу тулгараад байна шүү дээ.

Тэгэхээр тэр заалны агааржуулалт ямар байх юм, эрүүл ахуйн стандарт нь ямар байх юм, тэр заалны шалыг ямар стандартаар тавих ёстой юм, тэр биеийн тамирын хичээл сургалтын стандарт, норм нь ямар хэмжээнд байх юм үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бид нар гаргаж тавьж, хичээллүүлэх ингэж байж бүтээлч, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг эрхэмлэсэн ийм үндэстэн болох том зорилтын төлөө та бүхнийг хамтарч ажиллахыг уриалж байна.

Г.Занданиатар: Дэмжиж үг хэллээ. Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Гишүүдийн өргөн барьсан хуулийн төслийг дэмжиж

байгаа. Тэгэхдээ бид нар яг энэ өргөн барьснаар бол 0.5 мг-аас дээш бол тогтмол дүнгээр 500 төгрөг, 525, 550 гээд нэмсэн байна л даа. 8000 төгрөгөөр зарж байгаа ундаанд 500 төгрөг нэмэх болох тийм ч айхтар нэмэлт биш. 1000 төгрөгөөр зарж байгаа ундаанд 500-г нэмэх бол нэлээн өндөр, 50 хувийн өндөр болно л доо. Тэгэхээр энийг чинь тогтмол үнийн дүнгээр тавьдаг нь зөв үү? Бүтээгдэхүүнүүдийн үнэ өртөг өөрөө дотроо харилцан адилгүй. Чихрийн агууламжаасаа шалтгаалаад орж ирсэн импортын дотоодын үйлдвэрийн, жимсний төрлөөсөө шалтгаалаад үнэ нь маш өөр л дөө. Би бас дахиад л хэлье 15000 төгрөгөөр зарагдаж байгаа ундаа байх юм бол 500 төгрөг нэмэх юм бол ерөөсөө огт өөрчлөлт биш.

Гэтэл 1000 төгрөгийн ундаанд 500 гэдэг бол өндөр. Үүнийг заавал ингэлгүй шууд үнийн хувиар нэмэх ийм боломж байгаа юу? Үүнийг тавьснаар бол 0.5-аас дээш гэхээр бүгд 0.4 рүү тэмүүлнэ. Тэрийг бууруулах ямар механизм байж болох вэ? Архины хатуулгыг 38, 40 градусаас жил болгон бууруулж байгаа шиг 0.5-аас 4, 3, 2 руу бууруулсанд нь ямар урамшуулах механизм байж болох вэ гэдэг дээр та нар судалгаа хийсэн зүйл байна уу? Зөвхөн ундаа биш л дээ. Одоо сүүлийн үед бол энэ кофе шопууд их болсон. Хүүхдүүд энд асар их орж өдрийн хоол унд нь ер нь энэ торт, бэйкери нэл чихэр бараг хэдэн хувь ч байдаг юм сахар болсон энэ зүйлүүдийг бас давхар судалж үзсэн зүйл байна уу? Тэгэхээр эд нарыг бас давхар үзээд явах юм бол нэгэнт сахрын хэрэглээг бууруулах гэж байгаа дээр бас ямар бодол байна вэ гэдгийг би асуух гээд байна.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн хууль санаачлагч асуултад хариулна.

С.Одонтуяа: Тэгэхээр гишүүд бас маш зөв ойлголттой байна л даа. Ер нь энэ сахрын хэрэглээ бол үнэхээр манай улсад хэт их нэмэгдсэн байгаа. Энэ бид нар маш ол олон судалгаанууд хийсэн. Энэ дээр нэг асуудал юу вэ гэхээр сая гишүүд бас над дээр ирээд хэлж байна л даа. Зөвхөн ундаан дээр биш бусад хэт их чихэр ордог ийм нарийн боов дээр хийж болох уу гээд.

Тэгэхээр бид нар эхний ээлжид яагаад чихэрлэг ундаа гэж байгаа гэхээр судалгаа хийгээд үзэхээр хүүхдүүд чихэр идэх, нарийн боов амтат идэхээс 65 хувь нь яг чихэрлэг ундаанаас аваад байгаа юм. Том хүмүүс ч тэгсэн.

Тийм учраас бид нар эхлээд хамгийн их хэрэглээд байгаа тэр зүйл дээр нь энэ хуулийг хийгээд үзье, байдлыг хараад дараа нь бусад зүйл дээр бас шат дараатай бас хийж болох юм гэдэг зүйлийг ярьж байгаа юм. Жишээлэхэд энэ хууль өөрөө анх 24 оны 1 сарын 1-нээс хэрэгжинэ гэгчихсэн байсан одоо бид нар энийг 25 оны 1 сарын 1-нээс хэрэгжүүлэхээр бас анхны хэлэлцүүлэг дээр өөрчлөх хэрэгтэй юм билээ.

Яагаад гэхээр энэ хууль өөрөө өргөн баригдаад бид нар судалгаа хийгээд нэлээд удчихсан байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө татвар цуглуулах биш ерөөсөө л эрүүл мэнд рүү л чиглэсэн хууль байгаа. Тийм учраас бид бол үүн дээр сая Ганболд гишүүн зөв хэлж байна хүүхдүүд тэр аваад байгаа хямдхан ундаан дээр л хамгийн гол аюул нь байгаад байгаа юм. Хүүхдүүд дэлгүүрт ороод л 5000 төгрөг олж аваад л дэлгүүрт оронгуутаа

хамгийн хямдхан тэр чихэрлэг ихтэй ундааг аваад байгаа юм. Дандаа хиймэл, тэр нь хүнд ямар ч илчлэг байхгүй. Ялангуяа бага орлоготой айлуудад энэ чихэрлэг ундааны хэрэгцээ асар их хурдацтай нэмэгдээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар энэ эхний ээлжид ийм багаар тавьж байгаа юм. Тэр бусад урамшуулал энэ тэр байгаа юм уу гэдэг дээр манай ахлах зөвлөх хариулчих уу. 89 дүгээр.

Г.Занданиатар: 89.

П.Батхишиг: Батхишиг, гишүүний асуултад хариулъя. Үнийн дүнгээр ноогдуулж тавих татварын хэлбэрийг бас судалж үзсэн. Ер нь дэлхий дээр 89, бүс нутгаар бол 117 орон хэрэглэж байгаа энэ татвар дотор дийлэнх нь тодорхой дүнгээр, центээр, пэсоогоор гээд ноогдуулсан байгаа. Тэр нь яагаад ингэж байна вэ гэхээр шалтгааны хувьд үнийн мэдрэмж нь хамгийн өндөр буюу хэрэглээ хамгийн ихтэй хэсэг дээр энэ татвар өөрөө чиглэж өгдөг тэр утгаараа.

Хоёрт, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжүүдийг бас үзэхэд үнийн мэдрэмжээ хараад гол хэрэглэж байгаа сегмент зорилтот хэрэглэгчдэд аль нь илүү очиж байна вэ гэдгээрээ татварыг харсан нь зөв гэдэг утгаараа бид нар энэ энийг 500 төгрөг гэж ноогдуулсан байгаа. Бусад бүтээгдэхүүний тухайд сая Одонтуяа гишүүн хариулчихлаа. Ер нь жишээлбэл, Энэтхэгийг аваад үзэхэд сахрын импорт дээрээ буюу тэр сахар маань бүх бусад бүх бүтээгдэхүүнд ордог учраас гээд бас ингэж тавьдаг. Дотооддоо сахар үйлдвэрлэдэг улсуудын хувьд бас тийм хэлбэрүүд байна лээ. Монгол улсын хувьд бүгд импортоор орж ирдэг. Чихэрлэг

ундааны 92 хувийг дотооддоо үйлдвэрлэдэг учраас татварыг хураах, ноогдуулах тодорхой байдал талаасаа эхний алхам болох юм л гэж харсан байгаа. Бусад бүтээгдэхүүнийг яг нарийн судлаагүй байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Ганболд гишүүний асуулт байна шүү дээ. Гишүүд асуулт асууж, хариулт. Санаачлагч за, Батсүхийн Саранчимэг гишүүн.

Б.Саранчимэг: Ганболд гишүүний асуултад нэмж хариулахад бас тантай санал нэг байна. Сахрын хэт хэрэглээ хүний эрүүл мэндэд ямар их сөрөг нөлөөг угаасаа судалгаагаар харуулаад байгаа. Тэгэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллага, мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас энэ чихэрлэг ундаанд ноогдуулах татварыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэхийг улс орнуудад бас уриалж байгаа. Тийм учраас бас эмэгтэй гишүүдэд энэ 100 гр ундаанд 5 гр чихэр агуулагдвал ямар нэгэн татваргүй, түүнээс дээш чихэртэй ундааны хэрэглээг татвараар зохицуулах ийм төслөө өргөн мэдүүлсэн байгаа юм. Тэгэхээр энэ Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар энэ хэт чихэрлэг ундааны хэрэглээг бууруулахаас гадна бас иргэдийнхээ энэ эрүүл мэндийг хамгаалах ийм чухал ач холбогдолтой.

Нөгөө талаас энэ ихрийн агууламжгүй болон жүүс, ундааг татвараас чөлөөлөх, органик хүнс ундаа үйлдвэрлэгчдийг дэмжих замаар энэ эрүүл, аюулгүй хүнс ундааны хэрэглээг нэмэгдүүлэх нь эрүүл монгол хүнийг, нөхцөлийг бүрдүүлэх ийм зорилготой хуулийн төсөл байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглая.

Г.Ганболд: Үгүй харин тэгэхээр байна шүү дээ жаахан буруу л болоод байна л даа. Нэгэнтээ л 0.5 гр-аас дээш сахар гэх юм бол тэр үнэтэй ундаа нь ч 0.5-аас дээш адилхан, хямдхан ч адилхан шүү дээ. Хямдхан гэдэг чинь масс үйлдвэрлэлийн Кока кола, Пепси кола гээд энэ масс үйлдвэрлэж, хямдхан нийлүүлж байгаа юмнуудаа бид нар үнэтэй болгох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ бол өөрөө наад та хэдийн чинь нөгөө яриад байгаа юмнаас чинь зөрөөд байгаа байхгүй юу.

Тэгэхээр би үнийн дүнд нь харьцуулаад л энэ сахрыг л бид нар бууруулах гэж байгаа ийм хэмжээгээр нэмэх ёстой шүү дээ. Том үйлдвэрлэлүүд чинь арай хямдхан байгаа байхгүй юу. Тэд нар руу л чиглэсэн татвар байна шүү дээ наадах чинь. Тэгэхээр би бол энэ дээр яг ийм байдлаар бас дэмжихээргүй юм шиг байгаа юм мэдэхгүй.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүд үндсэндээ дэмжсэн, дэмжээгүй үг хэлсэн дээ. Дэмжиж үг хэлж болно. Үг хэлэх гишүүн Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ. Дараа нь санал нь санал хураалттай.

Ж.Чинбүрэн: Маш чухал хуулийн төсөл орж ирж байна. Тэгээд бас Одонтуяа гишүүнд бас баярлалаа гэж хэлмээр байна. Ер нь энэ хүүхэд насандаа сахрын хэрэглээг багасгах нь цаашидаа амьдралынхаа туршид сахрын хэрэглээг бага иддэг ийм судалгаанууд байдаг.

Ялангуяа энэ өндөр хөгжилтэй Сингапур энэ тэр орнуудад бүр тийм судалгаанууд хийсэн байдаг. Бага насны хүүхдүүд сургууль дээр нь өндөр сахрын агууламжтай ундаа өгөхөд хөөх ямар их сахартай юм бэ гэж хүртэл уухгүй байх. Нэг ёсондоо нөгөө давсны хэрэглээ ч гэсэн бид бас тийм болох хэрэгтэй. Давсны хэрэглээ ч гэсэн яг тэрэнтэй адилхан. Давс их, давстай байхад бас тэгдэг.

Тэгэхлээр би бас энэ Сарангэрэл гишүүнийхээ, Одонтуяа гишүүний энэ өргөн мэдүүлж байгаа энэ хуулийн төслийг бол хоёр гараа өргөөд дэмжиж байна. Үүнийг бид яаралтай хэрэгжүүлж, үүнийг амьдралын хэв дадалд хэвшүүлэх нь өөрөө их чухал юм. Бид бас ярьдаг ер нь энэ сахрын хэрэглээ өндөр байх нь зөвхөн сахрын ..., архаг хууч өвчин бий болгохоос гадна хавдрыг өдөөдөг том хүчин зүйл бол сахар. Хүний бие организм ялангуяа хавдрын эс бол гадаргуу дээрээ инсулин рецептор ихтэй сахрыг хамгийн амархан энергийн эх үүсвэр гэж үздэг учраас хавдрыг өдөөх, өсгөх хавдар үүсэхэд бас нөлөөлөх тийм магадлалтай ч байж магадгүй гэдэг ийм гипотез, таамгууд бас бас байдаг.

Тийм учраас бид энэ сахрын хэрэглээг багасгах чиглэлд энэ оруулж байгаа хуулийг бол гишүүд бараг бүгдээрээ шахуу дэмжих байх гэж найдаж байна. Хуулийн төслийг гишүүддээ бас дэмжиж санал өгөхийг уриалж байна.

Г.Занданшатар: Чинбүрэн гишүүн дэмжиж үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

21 гишүүн дэмжиж, 53.8 хувийн саналаар төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд ишлэжүүлж байна.

11.32 цаг

Үдээс өмнөх хуралдаан шуурхай хуралдаж дуусна. Даргын дэргэдэх зөвлөл 15 цагаас хуралдана. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно. Үдээс өмнөх хуралдаан завсарласныг мэдэгдье.

Нямаагийн Энхболд нарын 27 гишүүн ахмадын нийгмийн хамгаалал, асаргаа, сувилал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хамтрах, төр засгаас ахмадын талаар явуулж буй арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой лобби бүлэг байгуулж байгаагаа үүгээр уламжилж байна гэсэн байна. Нийт Нямаагийн Энхболд нарын 27 гишүүд бичиг ирүүлсэн байна. Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хотноо болсон Шинэ сэргэлтийн бодлого Ахмад настны оролцоо үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ оролцож Засгийн газрын зүгээс

баримталж буй бодлого, зорилгын талаар байр сууриа илэрхийлсэн. Тэгээд энэ талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход хууль тогтоох байгууллагын оролцоо чухал болсныг онцлон тэмдэглэж Улсын Их Хуралд лобби бүлэг байгуулан дэмжихийг санал болгосон болно.

Улсын Их Хурлын гишүүнийхээ хувиар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, судалгааны болон холбогдох бус байгууллагуудтай хамтран энэ чиглэлийн хууль тогтоомжуудыг шинэчлэх шаардлагатад нь нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар төслүүд боловсруулан гэрээ байгуулан ажиллаж байна.

Иймд ахмадын нийгмийн хамгаалал, асаргаа, сувилал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход хамтрах, төр засгаас ахмадын талаар явуулж буй бодлого, арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилготой лобби бүлэг байгуулж байгаагаа үүгээр уламжилж байна гэсэн. Ингээд Нямаагийн Энхболд наран болон нэр бүхий 27 гишүүн гарын үсэг зуржээ. Үүнийг мэдээллээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан завсарласныг мэдэгдье.

11.34 цаг

Баасан гараг 15 Арванхоёрдугаар сар
2023 Төрийн ордон “Их
хуралдай” танхим 14 цаг 01
минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ мэдээлэл хийнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар та бүхэндээ мэдээлэл хийе.

Манай орны ой Сибирийн их тайга, Төв Азийн хээр цөлийн торгон заагт уур амьсгалын эрс тэс нөхцөлд тархан ургах тул байгалийн аясаар тэлэн ургах боломж нэн хязгаарлагдмал, ой бүтээмж өсөлтийн хувьд бага, ой түймэр, хөнөөлт шавьж, өвчин болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлд хялбархан өртөмтгий эмзэг эко систем юм.

Манай орны ой, гол мөрний усны нөөцийг зохицуулах, хөрсний элэгдэл,

эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих, цөлжилтийг сааруулах зэрэг экологийн өндөр ач холбогдолтой.

Ойн сан нутгийн хойд хэсгийг эзлэх шилмүүст навчтай, нутгийн өмнөд талын говь, цөлийн бүсээр тархан ургах заган ойгоос бүрддэг. Үүний 74.6 хувийг нь навчит шилмүүст ой, 25.3 хувийг заган ой эзэлдэг. Ойн сангийн нийт талбай 2023 оны байдлаар 19 сая 79 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 12.2 хувийг эзэлж байна.

Аливаа улс орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт харьцуулж хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэдэг бөгөөд манай улсын энэ үзүүлэлт 8.28 хувьтай байна.

Ойн сангийн 2022 оны талбайг 2020 оныхтой харьцуулахад ойгоор бүрхэгдсэн талбай 167.4 мянган га-гаар нэмэгдэж, ойрхог чанар, чанарын эзлэх хувь 0.07 хувиар өссөн үзүүлэлт гараад байна.

Ойн сангийн нийт талбайн 35.7 хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт, 47.4 хувь нь хамгаалалтын бүсэд, 16.9 хувь нь ашиглалтын бүсэд тус тус хамаарагдаж байна.

Улсын хэмжээнд 2022-2023 онд 101 удаагийн ой хээрийн түймэр гарч, 1.3 мянган га ой, 1 сая 28 мянган га хээр, нийт 1 сая 29 мянган га талбай өртсөн. Түймрийн улмаас 1.85 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирч, түймрийг унтраахад 55.6 сая төгрөгийн зардал

гарч, нийт хохирол 3 тэрбум төгрөгт хүрээд байна.

Ойн харьяаны түймрийн 2022-2023 оны мэдээг 2021-2022 онтой харьцуулахад түймрийн тоо 72 тохиолдлоор, түймэрт өртсөн талбайн хэмжээ 14.7 мянган га-гаар, хохирлын хэмжээ 9.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлт гараад байна.

Ойн тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд тухайн жилд ойгоос бэлтгэж ашиглах модны дээд хязгаарыг аймаг, нийслэлийн Засаг даргын санал, ой зохион байгуулалтын судалгаагаар тогтоосон тооцоот хэмжээг үндэслэн аймаг, нийслэлээр тогтоож, энэ хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргээр, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аж ахуйн нэгж байгууллагаар тогтоодог.

2022 онд 1.3 сая куб метр ойн нөөц ашиглах дээд хязгаар тогтоосноос 720.7 мянган куб метр ойн нөөцийг ашиглаж улсын төсөвт 5.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх эх дэлхий байгаль орчноо хайрлан зохицон амьдрах, Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэх талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021 оны 10 сарын 4-ний өдрийн 58 дугаар зарлиг гаргасан билээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар та бүхэндээ тодотгон танилцуулъя.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний үр дүнд хүргэх амжилттай хэрэгжүүлэх гол үндэс суурь нь мод үржүүлгийн газруудыг дэмжих, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх ажил юм. Улсын хэмжээнд мод үржүүлгийн газруудын бүртгэл, тарьц суулгацын нөөцийн хэмжээг тодорхойлох ажлыг энэ жил зохион байгууллаа. Тооллогоор улсын хэмжээнд 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 76 иргэн, 25 нөхөрлөл, 351 аж ахуй нэгж байгууллага, нийт 21 овог 52 төрөлд багт багтах 124 зүйлийн 62.9 сая ширхэг тарьц суулгацын нөөцийг бүрдүүлсэн байна.

Энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад даруй 5 дахин өссөн үзүүлэлт бөгөөд үүнээс дүгнэхэд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэхэд бүрэн боломжтой болж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж эхэлснээс хойш 41.5 сая мод тарьж, зохих арчилгаа хамгаалалтын ажлыг гүйцэтгэж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш улсын хэмжээнд 39 зүйлийн мод сөөгийн 12.1 тонн үрийн нөөц бүрдүүлсэн. Энэхүү үзүүлэлт нь өмнөх жилүүдтэй харьцуулахад даруй 4.5 дахин нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд ойн үрийн чанарын холбогдох стандартуудын дагуу тоймлон үзэхэд дээрх үрийн нөөцөөр 39

төрлийн 291.7 сая сая ширхэг тарьц суулгац ургуулах боломжтой юм.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихаас гадна ойн санг хамгаалах ажил зайлигүй хийгдэх шаардлагатай байдаг. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг зохиох, тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох ажлыг 15 аймгийн 109 сумын 2.5 сая га талбайд хийж гүйцэтгэлээ. Ойн санг хөнөөлт шавжаас хамгаалах ажлыг энэ онд 265.8 мянган га талбайд улсын орон улсын болон орон нутгийн төсвөөр “Рио Тинто” ХХКомпаниитай хамтран хэрэгжүүлж буй “Эрүүл ой” төслийн санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулснаар 1 тэрбум модыг доройтолдо орох, өртөн хатан хуурайших эрсдэлээс хамгаалаад байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн төлөөллүүдийг хамарсан баруун бүсийн зөвлөгөөнийг Баянхонгор аймагт, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн төлөөллүүдийг оруулсан Зүүн бүсийн уулзалт, зөвлөгөөнийг Дорнод аймагт тус тус зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудад амлалт авсан уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагууд, аймгуудын холбогдох байгууллагуудын төлөөлөл хувийн хэвшил зэрэг оролцогч талуудыг хамруулсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор амлалт авсан уул уурхайн аж ахуйн нэгжүүд, банк санхүүгийн болон төрийн байгууллагын төрөлжсөн уулзалтуудыг зохион байгуулаа. Үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор оролцогч талуудыг хамруулсан уулзалтыг

долоо хоног бүрийн мягмар гарагт зохион байгуулж ажиллаж хэвшүүлээд байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.5-д заасан ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэх, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжид мөнгөн урамшуулал олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж заасан зорилтыг хангах болон “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

Зориудаар ойжуулах байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар хариуцсан ойг нөхөн сэргээх.

Гол нууруудын татмыг ойжуулах ажлыг 2.4 мянган га талбайд зохион байгуулж, 3,1 сая модыг тарих.

Ойн зохион байгуулалтын ажлыг 2.8 сая га талбайг хамруулан явуулж, ойн төлөв байдлын үнэлэх ажлыг зохион байгуулах.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор түймрийн 500км халз болон шороон зурвас шинээр байгуулах. Өмнө байгуулсан байгуулсан зурвасыг сэргээх ажлыг, сэргээхийг хийх.

Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг хязгаарлах, тоо толгойн нягтшилыг бууруулах тэмцлийн ажлыг 330 мянган га талбайд хамруулан зохион байгуулж 1.2 тэрбум модыг доройтолдо өртөхөөс урьдчилан сэргийлэх.

Ойг доройтлоос хамгаалах, түймрийн эрсдэлийг бууруулах зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлыг 1.3 мянган га талбайг хамруулан зохион байгуулах.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилтийг сааруулах хамгаалалтын ойн зурвасыг 130 га талбайг хамруулан зохион байгуулах.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор мод үрт үржүүлгийн нөөц бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газруудад техник, тоног төхөөрөмжийн тусалцаа, дэмжлэгийг үзүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Та бүхэнд танилцуулж дууслаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль, орчин аялал жуулчлалын сайд, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль, орчин аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга, Бямбасүрэнгийн Оюунсанаа Ойн газрын дарга, Батхишигийн Ганзориг Ойн газрын Ойн нөхөн сэргээлтийн хэлтсийн дарга.

Дараа нь даргын дэргэдэх зөвлөлтэй. Ирэх долоо хоногоор энэ өвөлжилтийн байдлыг хэлэлцэх асуудал дээр даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд оролцоорой. Одоо яг гадаа 26 градус хүйтэн байна. Цаг агаар эрс хүйтэрч байна. Саяхан болсон цасан шуурга, цочир хүйтрэлтээс болж иргэд, малчид амь насаа алдсан харамсалтай хэрэг

явдал болсон. Ийм учраас энэ хагас, бүтэн сайны өдрүүдэд гишүүд орон нутагтаа ажиллаж, малчдын өвөлжилтийн байдалтай танилцаж, энэ дутагч гачигдаж байгаа асуудлыг анхаарч ажиллах шаардлагатай.

Тийм учраас өнөөдөр бас их олон гишүүн хөдөө чөлөө аваад явчихсан байгааг би бас зориуд тэмдэглэж хэлж байгаа юм. Завхан хүндрэлтэй Цэрэнпунцаг, Баярсайхан гишүүн хоёр чөлөө аваад явсан. Сүхбаатар чөлөө аваад явчихсан. Сүхбаатар аймгийн гишүүд. Тийм ер нь гишүүд нэлээн хөдөө явчихсан байгаа.

Тийм учраас хагас, бүтэн сайн 5 дахь өдрийн ирц ийм байгаа гэдгийг бас анхаараарай. Энэ өвөлжилтийн байдал, энэ түлш шатахууны нөхцөл байдал, эрчим хүчний хангамжийн асуудал гээд хөдөө орон нутагт тулгамдаж байгаа энэ асуудлыг газар дээр нь ажиллаад ирэх долоо хоногийн хэлэлцэх асуудал дээр энийг яаж анхаарч, шийдэл гарц юу байна тэрийг бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон холбогдох бусад сайд нар бас асуудлаа оруулж ирнэ гэсэн. Ярилцъя. Ингээд энэ асуудал дээр ер нь бүгд хаа хаанаа их сайн анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ эрт өвөл болж, эрт хүйтэрч байгаа нь бас энэ өвлийн нөхцөл байдлыг бас нэлээн хүндрүүлж байгаа. Одоо мэдээлэлтэй холбогдуулж цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхийн дулаарал, уур амьсгалын нөлөө хүний хүчин зүйлээс шалтгаалан

манай улсын нутаг дэвсгэрийн 76 хувь нь цөлжилтөд өртсөн энэ цаг үед ой, ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн, усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх нь тулгамдсан асуудал болж буйтай бүрэн санал нэгдэж байна.

Монгол Улсын ойн нөөцийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээхэд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн чухал ач холбогдолтой юм. Харамсалтай нь уг хөдөлгөөний ажлын явцыг харвал тавьсан зорилгодоо хүрэх боломжгүй байна. Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, төлөвлөж буй ажлыг нэгтгэн дүгнэвэл тавьсан зорилтдоо хүрэхгүйгээс гадна асуудлынхаа мөн чанараас хол, тогтвортой хөгжлийн бодлого байхгүй, арга барилын хувьд хоцрогдсон захиргааны аргаар шийдвэрлэх гэж ажиллаж байна. Мөн цаг уурын өөрчлөлт түүнд нөлөөлөх аливаа бодлогууд дээр баруун төвийн намууд өөр байр суурьтай байдгийг бас сануулж хэлэх нь зүйтэй. Өнөөг хүртэл гаргасан алдаа, залруулга, холбоотой зарим бодлогын саналуудыг бас танилцуулъя.

Ойн тогтвортой менежментийн бодлого бий болгож чадаагүй байна. Ой газрын хөрсөн дээрх баялаг. Ойжуулах, ойг нөхөн сэргээх, ой хамгаалах үйл ажиллагаа нь ойг зохистой ашиглах бодлоготой уялдаж иргэдэд үр өгөөжөө өгдөг тогтвортой менежментийн бодлого боловсруулан хэрэгжүүлж байж энэ ойжуулах үндэсний хөдөлгөөн амжилтад хүрнэ. Нэн тэргүүнд Засгийн газар ойн тогтвортой менежментийг бий болгох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Мэдээллээс харахад 2022 онд ойгоос олсон орлого 5.7 тэрбум төгрөг болж ДНБ-ий 100-ны 1 хувь орчимтой тэнцэж байгаа нь маш

чамлалттай үзүүлэлт. Тодорхой хэлбэл бид ойгоо ашиглаж чаддаггүй. Тэр хэрээрээ иргэд ойгоо тэлж хамгаалах ч сонирхолгүй байна. Тиймээс ойн экосистемийг хадгалах, ойг нөхөн сэргээх, ойжуулах ажил нь иргэдэд үр өгөөжөө өгдөг эдийн засгийн утга бүхий тогтолцоог нэн тэргүүнд бүрдүүлэх шаардлагатай.

Засгийн газрын 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ойн асуудлаар орсон ганцхан заалт болох 5.1.5 дахь заалт нь ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 8.6 хувьд хүргэж, мод тарьж ногоон хөгжилд хувь нэмрээ оруулсан иргэд, аж ахуйн нэгжид урамшуулал эдийн засгийн харилцаатай болгоно, энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн.

Гэхдээ энэ заалтад хэрэгжилт байхгүй байна. Ийнхүү биелэгдэхгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн дутагдал гэхээсээ илүүтэйгээр бодлого тодорхойгүй байгаатай холбоотой. Мөн ойн зохистой ашиглалт бол урт хугацаанд ойгоо хамгаалах, ойн хэмжээг тэлэхэд шаардлагатай бас санхүүжилтийн эх үүсвэр. Засгийн газрын 350 дугаар тогтоолоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний шаардагдах зардлыг жил болгон улсын ба орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхээр заасан хэдий ч 22 онд, 23 онд төсөвт тусган санхүүжүүлж байгаа нь зорилтот түвшинд хүрэхэд нэн хангалтгүй юм.

Цаашид ч болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж чадахгүй гэж үзэж байна. Иймд энд “Эрдэнэт” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Эрдэнэс Тавантолгой”, “Эрдэнэс Монгол”, “Оюу толгой”,

“Монголросцветмет гэх зэрэг төрийн өмчийн оролцоотой олон аж ахуйн нэгж байгууллага мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага, хил хамгаалах байгууллага, онцгой байдлын газар гэх зэрэг байгууллагууд олон зуун мянган мод тарьжээ.

Гэхдээ эдгээр байгууллагууд мод тарихад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг нээлттэй болгож тайлагнаагүй байгаа нь дараагийн бас асуудал гарах вий гэсэн болгоомжлолыг олон нийтэд төрүүлэх нь ойлгомжтой. Мөн эдгээр ажлыг хэрэгжүүлсэн сонгон шалгаруулалтын явцын мэдээ ,тайлан ч бас байхгүй байна.

Төрийн өмчийн байгууллагууд энэ мэтээр зардал гаргаж мод тарьж байгаа нь үндсэн үйл ажиллагаанаас гадуур сайн дурын шинжтэй бөгөөд мэргэжил арга зүйн хувьд алдаа дутагдал гарах нь ойлгомжтой. Ойн эко системийг хамгаалах, ойжуулах ажил бол шинжлэх ухааны үндэслэлтэй хийдэг мэргэжлийн үйл ажиллагаа. Тиймээс ойн тогтвортой менежментийн бодлоготой уялдуулсан хүний нөөцийг чадавхжуулах, бие даасан хөтөлбөр шаардлагатай юм.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд ойжуулалт, ойн ашиглалтын чиглэлээр турилага хуримтлуулсан улс орнууд, олон улсын байгууллагуудын турилага тусалцаа, хамтын ажиллагаа зайлигүй шаардлагатай. Ойжуулах ажлыг зөвхөн суулгац суулгаснаар биелж байгаа юм шиг хандаж ирсэн өнөөгийн хандлага нэн даруй залруулж, ой, усны сав газрын бодлогыг уялдуулан авч үзсэн иргэдийн оролцоонд тулгуурласан хүний нөөцийн бодлого боловсруулах шаардлагатай.

Өнөөгийн арга барилаар ажиллавал “Тэрбум мод” хөдөлгөөн, том зорилтууд, сайхан санаачилга амьдрал дээр биш зөвхөн цаасан дээр үлдэх нөхцөл бүрдээд байгааг бас анхааруулна гэж сануулъя. Түүнчлэн өнөөг хүртэл Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө ТӨК-уд, төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэн иргэд олон нийтэд бас нээлттэй мэдээлэх нь зүйтэй.

Цаашид иргэдийнхээ оролцоогүйгээр захиргааны арга хэрэгслээр аливаа асуудалд хандах нь эцэстээ мухардалд орж, улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан үйлдэл болох вий гэдэгт бас анхааран сануулъя.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Одоо мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух цөөнхийн бүлгийн гишүүд. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьяаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяаа: Энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга байгаа. Цөлжилт энэ хуурайшилтын үед Монгол орон түүний дотор ер нь дэлхий нийтээрээ энэ уур амьсгалын өөрчлөлтийн үед бол Монгол Улсын төрийн тэргүүний хувьд ийм санаачилга гаргаж ажилласан нь бол бас цаг үеэ олсон, Монгол Улс бол бас Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүний хувьд хариуцлагатай ийм үйл ажиллагааг олон улсын хэмжээнд уриалж, хүн төрөлхтнийг энэ цөлжилт, хуурайшлаас

сэргийлэхэд их чухал ач холбогдолтой зүйл болсон гэж ингээж Улсын Их Хурлын гишүүний хувьд ингээж бодож байдаг юм.

Монгол Улсын Засгийн газраас энэ “Тэрбум мод” хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлэх, иргэд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагууд олон улсын байгууллагатай хамтарч ажиллахад бас нэлээн бас санаачилгатай ажиллаж ирсэн гэдэг ийм байр суурьтай байна. Ингээд Монгол Улсын Байгаль орчны сайдаас хоёр, гурван зүйлийг асууя.

Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн сав захиргаа гэж Монгол Улсын хэмжээнд олон газруудыг бид тусгай хамгаалалтад авч, байгаль орчноо хамгаалах, унаган төрхийг нь алдагдуулахын тулд ажиллаж ирсэн. Тухайн сав газрын нутаг хилийн цэст амьдардаг малчдад бол нэлээн ийм тулгамдсан асуудал байна. Тэнд ажиллаж, амьдардаг, малаа малладаг малчдад тэр газрыг нь олгох, өвөлжөө, хаваржааны газрыг нь олгох, тэнд хадлан, бэлчээрээ хамгаалах, малаа тэжээх зориулалтаар бол тодорхой хэмжээний газрыг бол торлож авсан байдаг. Гэтэл энд бол байгаль орчны тухайн сав нутагт ажилладаг захиргааны байгууллагуудаас тэр малчдын өвөлжөө, хаваржааны газрыг олгох асуудал дээр бас нэлээн асуудал үүсгэдэг.

Түүнчлэн тухайн сав нутагт хадлангийн зориулалтаар торлож авсан тийм газрыг нь бас ашиглуулахгүй байх талаар бас нэлээн үл ойлголцол үүсэж байсан. Энд бол Байгаль орчны сайд энэ асуудлыг би олон удаа тавьсан. Энд бас нааштай шийдвэр гаргаж Ховд аймгийн Манхан, Чандмань, Дөргөн сумын нутаг дээр энэ асуудлыг газрын менежментийн

төлөвлөгөөнд оруулна гэж шийдсэн. Энэ асуудал ямар шатдаа байна? Одоо энэ талаар бол энэ газрын менежментийн төлөвлөгөөг баталсан байх ёстой энд энэ хэр, ямар байдлаар батлагдсан бэ гэдэг асуудал байна.

Түүнчлэн энэ олон улсын байгууллага, Монгол Улсын Засгийн газар төсвийн хөрөнгөөр олон ажлуудыг энэ цөлжилт, хуурайшилтад хамгаалах талаар асуудлууд хийдэг. Энэ усны газрын дарга гээд энэ Батбаяр гээд энэ нөхөр байдаг юм энэ манай Ховд аймгийн харьяат. Тэр хүн их санаачилгагүй ажиллаж байгаа гэж бодож байгаа. Тэр төсөл хөтөлбөрүүд ялангуяа энэ хуурайшилт цөлжилттэй холбоотой Ховд аймаг руу хийсэн ийм хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагаас татаж ирсэн хөрөнгө мөнгөний асуудал ерөөсөө байхгүй байна. Энэ дээр энэ баруун бүс нутаг, түүний дотор цөлжилт, хуурайшилтын бас гол цэг болсон энэ Их нууруудын хотгорын ай сав газарт бол энд ямар байр суурьтай байгаа вэ? Түүнчлэн бол энэ Их нууруудын ай сав газар Монголын цэвэр усны нөөцийн 70 гаруй хувь байдаг энэ бүс нутагт энэ нефтийн өрөмдлөг явуулна гэдэг ийм зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газраас өгсөн байсан. Тэгээд тодорхой хэмжээгээр үүнийг хязгаарласан гээд надад Уур уурхайн сайдаас албан ёсоор хариу ирүүлсэн. Энэ хязгаарласан асуудал нь яг бодитой үнэн үү? Ер нь өнөөдөр энэ Ай сав газрын тухай хууль, түүнчлэн энэ Их нууруудын хотгор энэ Монголын цэвэр усны нөөц байдаг энэ газарт энэ нефтийн өрөмдлөг, ашигт малтмалын өрөмдлөг явуулахад энэ Байгаль орчны яамны зүгээс ямар байр суурь баримталж байна гэдэг талаар хариулт авъя.

Г.Занданшатар: 83 Бат-Эрдэнэ сайд. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Тусгай хамгаалалттай газар нутгийн холбоо бүхий асуудал дээр ялангуяа тухайн орон нутгийн иргэд, малчдын асуудал ихээр хөндөгддөг. Энэ дээр бид нар намрын чуулганд өргөн барихаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг бэлэн болгосон байгаа. Энэ бэлэн болгосон хууль бол Газрын тухай, Газрын багц хуулийг дагалдуулж оруулахаар өргөн барихаар бэлэн болгоод, ер нь зүгээр Монгол Улсад үүссэн энэ газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй газар олгогдож байснаас улбаатай маш олон асуудлууд бий. Үүнийг бид нар нэг мөр шийдвэрлэх шаардлагатай гэж харж байгаа. Энэ утга агуулгын хүрээнд бол Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг заавал гаргадаг байх, тухайн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэж байж газрыг олгодог байх гэдэг энэ зарчмыг бол оруулж өгч байгаа.

Малчидтай холбоо бүхий асуудал бол энэ сүүлийн үед бол ихсэж байгаа. Энэ асуудал цаашидаа бүүр ихэснэ. Яагаад гэхлээр Монгол улсын нийт газар нутгийн 75 хувь нь бэлчээр, түүний 57 хувь нь доройтчихсон. 2050 он гэхэд өнөөдрийн байгаа хөрсний доройтол, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай холбоо бүхий асуудлаас үүдэлтэйгээр дахиад тодорхой хэмжээнд бас явагдахаар байна. Тухайлах юм бол 2050 он гэхэд агаарын хэм 2.6 хэмээр нэмэгдэнэ. 2080 он гэхэд агаарын хэм 6.2 хэмээр нэмэгдэнэ. Ингээд тооцоод үзэх юм бол тодорхой

хэмжээнд энэ цөлжилтийн асуудлууд, хөрсний асуудлууд бол ялт ч байхгүй хөндөгдөж байгаа. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дээр бол бид нар энэ тухайн орон нутагт амьдарч байгаа малчдын асуудлыг бол газар олгохтой холбоо бүхий асуудлыг бол газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан хэлбэрээр олгохоор ийм зохицуулалтыг хийж өгч байгаа.

Хадлан бэлчээртэй холбоо бүхий асуудал. Ялангуяа хадлан, идэш тэжээлтэй холбоо бүхий асуудал дээр одоо та бас өөрөө мэдэж байгаа тодорхой хадланг бэлтгэх боломжийг Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанууд хангаж өгөх байдлаар бол ажиллаад явж байгаа.

Олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой асуудалд улсын төсөвтэй холбоотой асуудлуудыг зүгээр хөндөөд өнгөрлөө гэж ойлголоо. Олон улсын төсөл хөтөлбөртэй холбоотой асуудал дээр бол өмнө нь явагдаж байсан “Ногоон хэрэм” төсөл бол үргэлжилж байгаа. Шинээр бол 2022 оны 5 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсад болсон дэлхийн ойн чуулган дээр бол АПЕК, Ази, Номхон далайн энэ бүсээс бол бид нар бас 1 сая долларыг Дорнод аймагт босгож, мод үржүүлгийн газар байгуулах, мод бүс байгуулах, ойн ногоон зурвасын бүс байгуулах энэ хэлбэр дээр бол төсөл, хөтөлбөрийг Монгол Улсын талаас бол оруулж, энэ төсөл дэмжигдсэнээр бол Дорнод аймагт бол 1 сая долларын төсөл, хөтөлбөр хэрэгжих ийм боломжтой болсон байгаа.

Халзан бүргэдийн асуудлыг хөндөж байх шиг байна. Халзан бүргэдээ бол зогссон байгаа. Энэ бол Монгол

Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ бол Ховд аймагт хийсэн уулзалт дээрээ иргэдээс олон санал гарсан. Үүний дагуу бол Уул уурхайн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам бол хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Энэ ажлын хэсгийн дагуу бол тодорхой хэмжээнд бол тухайн ажил Халзан бүргэдийн асуудлууд бол бүрэн зогсоод ийм байдалтайгаар явж байгаа.

Ер нь бол Монгол Улсын Засгийн газраас барьж байгаа бодлого бол тухайн орон нутгийн иргэдийн санал, санаачилгыг түрүүлж авах, тэр санал, санаачилга дээр тулгуурласан хууль, эрх зүйн хүрээнд хуулийн дагуу тодорхой хэмжээний арга хэмжээг авч ажиллах гэдэг ийм чиглэл дээр бол явж байгаа. Тэгэхээр саяын таны асуусан 3 асуулт бол ийм байна. Баярлалаа.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн нэмж асууя.

Ш.Адьшаа: Халзан бүргэдээс энд орно. Ер нь Хар ус нуурын ай сав газрын нутаг дэвсгэрт байдаг 8 сумын нутаг дэвсгэрийг хамарсан ийм газар нутгийг нефтийн хайгуул гэдэг хэлбэрээр ийм хайгуулын лиценз олгосон байсан. Энэ асуудлыг л яриад л байгаа юм.

Нөгөө талаасаа Бат-Эрдэнэ сайдын болгоомжлол байгаа зөв. Бид нар энэ 30 жилийн хугацаанд энэ Богд уулаа цементэн ширэнгэ болгосон. Үүнтэй энэ малчдын өвөлжөө, хаваржааны газар, малчдын тэр өвс тэжээлээ бэлтгэх тэр хашиж авсан хашаа хороо энэ тэр ойлгож болохгүй. Энэ нэг талаасаа энэ малчид энэ өвөлжөө, хаваржаагаа хашиж, хадлан бэлчээрээ хашиж байгаа нь бас байгаль орчноо хамгаалж,

цөлжилтөөс хамгаалж байгаа асуудал гэдгийг л ойлгох хэрэгтэй. Ийм учраас энийг яаралтай шийдэх нь өнөөдөр тэр малчдын асуудал байгаль, орчноо хамгаалах ч асуудал орно.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ер нь “Тэрбум мод” тарина гэдэг ийм санал санаачилгыг Монгол Улсын Ерөнхийлөгч олон улсын нэр хүндтэй хурал дээр амлаж, ингэж санал санаачилга гаргасан. Энэ ажил маань та нараар дамжихаараа л уначхаад байх юм. Ер нь Монгол Улсын Ерөнхийлөгч зөв зүйтэй санаачилга гаргаад, зөв зүйтэй эхлэлийг тавьдаг. Тухайлбал, энэ Улаанбаатар хотыг утаагүй болгох гээд түлш, нүүрсийг оруулахгүй гээд ингэж байсан. Тэр үед Улаанбаатар үнэхээр утаагүй болсон шүү дээ. Эхний 2, 3 жил бол. Тэгээд л бөөнөөрөө Улаанбаатарт Их Хурлын гишүүд болоод л гарсан. Тэрний хүчинд та сайд хийж байгаа байх. Нефтийн үйлдвэрийг анх санаачлаад л гаргасан. 23 онд ашиглалтад оруулна гэсэн.

Тэгээд л Ерөнхийлөгч болоод л явангуут тэр ажлыг нь унагааж байгаа шүү дээ. Ийм зөв зүйтэй санаачилгууд гаргадаг. Өнөөдөр “Тэрбум мод” маань яг хэдэн мод тарьчихсан юм? Яах вэ Ерөнхий сайд бас их хичээж байх шиг байна. Авлигатай тэмцэнэ гээд. Тэрийг нь энэ Засгийн газар нь сайд нар нь дэмждэг ч юм уу, үгүй ч юм уу. Ер нь 10 сайд солих цаг болсон. Энэ орон нутагт дарга даамал хийж байсан, аймаг удирдаж байсан Батжаргал гишүүн, энэ Ганболд гишүүн энэ тэрийг сайдаар тавих цаг нь болсон. Энэ Жаргалмаа энэ тэрийг. Эдийн засгийн үнэхээр мэддэг доктор хүн ч энд сууж л байна шүү дээ.

Баттөмөр гишүүн байна. Ийм маягаар цаашиа үргэлжлүүлэх цаг болсон.

Одоо Ерөнхий сайд хэнтэй ч хариуцлага тооцож чадахгүй байна. Та сая ярилаа Баянхонгорт хурал хийлээ гээд. Үгүй ер нь тэгээд хурал тэр уриа лоозон чинь хэтэрлээ шүү дээ. Ерөөсөө үр дүн байхгүй. Баянхонгорт хэдэн мод тарьсан юм? Ер нь Монгол Улс бол 15 хувь нь ой модтой байсан. Мэдээж хэрэг дэлхийн дулааралтай холбогдоод энэ та бүхний ажилтай холбогдоод 5, 6 хувь нь л модтой байгаа. Өмнө байсан юмаа сэргээх юу болж байна? Миний мэдэхийн Баянхонгор аймгийн яг Түйн гол дагуу бургасаар битүү байсан. Тэр хэрэгтэй, хэрэггүй хурал хийж хэдэн төгрөг үрж байхын оронд хэдэн мод тарьчхаад ирсэн юм бэ? Тэр ойн нөхөрлөлийн тухай хууль гарсан байгаа. Иргэд нь мод тариад ингэвэл шагнал урамшуулал өгнө, тэрийгээ тарьснаасаа гадна намар болохоор л бүх дарга нар гараад л хувинтай ус, хүрз бариад л баахан мод тарьж байна гээд жүжигт тавьдаг. Тэр нь ургадаггүй. Дараа жил нь тэрийгээ ахиад л хийдэг. Ийм л байдалтай явж байгаа шүү дээ.

Ер нь бид бүхэн хөдөө аж ахуй хаанаа анхаарах цаг болсон. Үүнийг ч бусад улс орнуудаасаа суралцмаар байгаа. Энэ манай урд хөрш гэхэд цөлжилтийн эсрэг яаж амжилттай тэмцэж байна. Үнэхээр автоматжуулаад, мод тарих, услах тэр бүх юмыг иж бүрнээр нь шийдэж байна шүү дээ. Ийм зүйл алга. Сая цухас дурдаад өнгөрлөө. Энэ Улаанбаатарт чинь ямар ч ногоон байгууламж алга Байгаль орчны сайд аа. Энэ Улаанбаатарын Богд уул чинь уг нь дархан цаазтай газар. Энэ суга болгонд нь танай намынхан л тэр авлигынхаа

мөнгөөр байшин барилга босгож байна шүү дээ. Хамгийн эртний дархан цаазтай газар шүү дээ энэ чинь. Дэлхийн түүхэн дэх. Өнөөдөр эндэх ойрхон ийм юмаа шийдэж чадахгүй ийм л болчихсон байна. Ямар ч сайн сайхан зөв санаачилгыг цааши нь үргэлжлүүлээд яваад ажил хэрэг болгож чадахгүй байна. Тэгээд нөгөө ажил муу газрын хурал, уриа лоозон ихэсдэг, тэгээд муу махыг гурилд боож далд оруулдаг, тааруу хүүхнийг торгонд боож далд оруулдаг иймэрхүү маягтай л ажил хийж байна шүү дээ та нар. Айн тийм ер нь хариуцлага ярья даа, больё. Ер нь манай гишүүд ч гэсэн та хэд нь одоо ажиллаад үз. Ажил амьдралын арвин туршилагатай хүмүүс байна шүү дээ энэ дотор чинь. Тэгээд хэдэн мод тарьсан юм, яаж ургаж байгаа юм, үр дүн нь ямар байгаа юм гэх мэтчилний зүйлийг чинь сонсьё доо. Тэр нөхөрлөлийн талаар хууль гаргасан ер нь хууль зөндөө гаргаж байгаа шүү дээ. Юу ч хэрэгжүүлдэггүй.

Г.Занданишатар: 83 Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Ганбат гишүүний асуултад хариулъя. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн дээр хөдөлгөөний гол бодлого концепц бол үндсэн бодлого, хөтөлбөрөө гаргаж аймгууд маань, аж ахуйн нэгжүүд маань, иргэд маань мод тарихтай холбоо бүхий асуудал тэрбумаар тоологдох модыг тарьж ургуулъя гэдэг.

2021 оноос эхэлсэн энэхүү хөдөлгөөн бол өнгөрсөн хугацаанд 41.5 сая модыг тарьж ургуулсан ийм дүгнэлттэй байгаа. 2023 онд бол 61.7 орчим сая тарьц суулгацыг бэлтгэсэн байна. Энэ бол 2024 оноос таригдаад эхэлнэ. Баянхонгор аймагт 325408 модыг

тарьсан, ургуулсан ийм дүгнэлттэй байгаа. Бид нар ялангуяа хөв цөөрөм байгуулах байдлаар бид нар бас тодорхой хэмжээний ажлуудыг явуулж байгаа. Таны хэлсэн Бүгд Найрамдах Хятад Ард Улстай, цөлжилттэй холбоотой маш сайн явж байна гэдэгтэй холбоо бүхий асуудал хөндөгдөж байна. Монгол Улсын хувьд бол нийт газар нутгийн 76.9 хувь нь тодорхой хэмжээний цөлжилтөд нэрвэгдсэн. Үүнээс бол нэн хүчтэй болон хүчтэй цөлжилтөд нэрвэгдсэн талбайн хэмжээ бол 21.3 хувьтай байгаа. Бид нар Монгол Улсын нийт газар нутаг буюу 1564116 км квадрат газар нутгийг 3 хувааж байгаа. Ногоон бүс, цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс, цөлжилтөд нэрвэгдсэн бүс гэдэг хэлбэр дээр хувааж ажиллаж байгаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бид нарын нэгдүгээрт тавьж байгаа зорилго бол ногоон бүс буюу цөлжилтөөс урьдчилан сэргийлэх байдлаар бид нар эхний алхам, ажлуудыг бид нар хийж явж байна. Үүнийг хийж хамгаалалтын бүс, ногоон зурвасаа байгуулж байж дараагийн түвшинд бид нар тодорхой хэмжээний ажлуудыг хийнэ гэсэн ийм хэлбэр дээр бид нар 70 хувиа ногоон бүс дээрээ тавьж явж байна.

Цөлжилтөд нэрвэгдэж байгаа бүс дээр бол бид нар тодорхой хэмжээний мод тарих ажлууд бол 30 орчим хувьтай явж байгаа. Цөлжилтөд нэрвэгдсэн бүс дээр тодорхой хэмжээнд явж байгаа боловч энд Ойн тухай хуульд тодорхой өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай гэж харж байгаа.

Улаанбаатар хотын хувьд бол 2 сая орчим ширхэг модыг бол тарьж ургуулсан ийм дүгнэлтүүд байгаа. Яах вэ

3 газар бол хамгийн их мод тарьж ургуулсан байгаа. Улаанбаатар хот, Орхон аймаг, Сэлэнгэ аймаг гэдэг энэ 3 газар бол хамгийн их мод тарилттай, ургалттай явж байгаа.

Дархан цаазат газар буюу Богд хан уултай холбоотой асуудлыг та хөндлөө. Энд бол танай нам, танай, манай гэж хэлэлтгүйгээр энэ тухайн үед улс төрийн албан тушаал хашиж байсан нөхдүүд дүүрэн байгаа. Шаардлагатай бол би танд тодорхой хэмжээнд мэдээллүүдийг гаргаж өгч болно. Бид нар 2023 оноос энэ газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг бий болгохтой холбоо бүхий асуудлыг хөндсөн. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулахтай холбоо бүхий асуудлыг хөндсөн. Энэ асуудлууд маань бэлэн болчихсон явж байна. 2023 онд нэг ч газар олголтыг хийгээгүй. 2023 онд Богд хан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаатай хамтраад 5594 га талбайг бол бид нар тусгай хамгаалалт буюу энэ хамгаалалтын бүс рүү нэмж авсан. Энэ хэмжээгээр хязгаарлалтын бүс бол багассан гэсэн үг.

Газар цуцлалтын хэмжээ мянган га-д хүрсэн. Бид нар төлөвлөлтгүй газар олголтоос улбаатай үүсэж байгаа хор уршиг, үр дагавруудыг монголчууд бид нар бүгдээрээ хүртэж байгаа. Ийм утга агуулгын хүрээнд бол бид нар өнөөдөр газар цуцлалтыг чухалчилж байгаа. Горхи-Тэрэлж, Богд хан уулын дархан цаазат хамгаалалтын газрын захиргаа, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын захиргаа Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газар гэдэг ч юм уу гэх мэтчилэнгээр бол газар цуцлалтын ажлуудыг бол бид нар тодорхой хэмжээнд явуулж байгаа.

Түрүүний хэлсэнчил хэлсэнчлэн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол зөвхөн мод тарьж ургуулах асуудал биш. Энэ бол хөрсийг хамгаалахтай холбоо бүхий асуудал, энэ бол цэвдгийг хамгаалахтай холбоо бүхий асуудал. Сүүлийн 80 жилийн хугацаанд цэвдэг маань 33 хувиар багассан. Монгол Улс бол цэвдгийнхээ тоогоор тархалтын тоо тархалтын хэмжээгээр бол дэлхийд 5-д ордог. Оросын Холбооны Улс, Канад, Америк, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, үүний дараагаар Монгол Улс ордог. Энэ дэлхийн дулаарал уур амьсгалын өөрчлөлттэй холбоо бүхий асуудлаас үүдэлтэйгээр бид .../минут дуусав./

Г.Занданшатар: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Хөдөө ч тэр, хотод ч тэр ногоон байгууламж байхгүй. Монгол Улсын 70, 80 хувь нь цөлжчихсөн байгаа. Аягүй бол дараа жил гэхэд бараг 90 хувь цөлжчих юм байгаа биз. Энэ уур уурхайтай холбогдсон хэдэн асуултыг тавья. Баянхонгор аймагт Их говийн дархан цаазтай газар гэж байгаа. Тэрний наана нүүрс, алт олборлоно гээд замаа тавиагүй байж машин их явж байна. Нөгөө эмзэг экологийн системийг говийн байхгүй болгож байна. Жинстийн цагаан ямаа гэж байдаг ноолуураар дэлхийн нэг номер. Тэнд бэлчээр нь талхлагдаж байна. Тэнд ажиллаж амьдарч байгаа малчдаасаа асуудаг, тэр талаар анхаардаг ийм Засгийн газар, ийм дарга нар байхгүй болчихжээ.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Монгол Улс эдийн засгийг сэргээх бодлогуудыг явуулж байгаа. “Алсын хараа-2050” “Шинэ сэргэлтийн бодлого”, тодорхой бодлого, хөтөлбөрүүд маань ч гэсэн амжилттай хэрэгжиж байгаа гэж бодож байгаа. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн томоохон үзүүлэлтүүд бол уул уурхайгаас хамааралтай байгаа. Бид нар уул уурхай, түүн дотроо хариуцлагатай уул уурхайтай хэрхэн зэрэгцэн орших вэ гэдэг тухай л өнөөдрийн байдлаар хөндөж байна. Байгаль орчны тухай хуулиудад өөрчлөлт оруулахаар бид нар явж байгаа. Зэрэгцээ түвшин дээр Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орохоор бас явж байна. Энэ тодорхой хэмжээний эрх зүйн өөрчлөлтүүд бол ороод явах байх. Өнөөдөр бол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд бид нар үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Бэлчээр, ноолууртай холбоо бүхий асуудал. Монгол Улс 71 сая малтай. Үүн дотроо 30 сая ямаатай. Өвс, ургамал үрээ цацаж чадахгүй хэмжээнд очсон байна. Малын бэлчээр талхлагдаж байгаа. Бид нар.../минут дуусав./

Г.Занданшатар: 83 Бат-Эрдэнэ сайд гүйцээгээд хариулчих.

Б.Бат-Эрдэнэ: Бид нар цаашидаа хосолмол хэлбэр рүүгээ орохгүй бол дан нүүдлийн хэлбэр дээр бэлчээрийн мал аж ахуйн чиглэл дээр энэ янзаараа явах юм бол сүүлдээ ямар ч бэлчээргүй болно. Би дөнгөж сая хэлсэн нийт газар нутгийн маань 57 хувь бэлчээрийн 57 хувь нь доройтчихсон байдалтай байгаа. Өнөөдөр бэлчээрээс улбаатайгаар малчид, аймгийн удирдлагууд хоорондын асуудлууд хүртэл үүсээд эхэлчихсэн түвшинд байна. Тэгэхээр бид нар бэлчээр

болон эрчимжүүлсэн гэдэг энэ хэлбэрийг агуулах ёстой гэж харж байгаа. Өнөөдөр бэлчээрийн мал аж ахуйн эрхэлж байгаа иргэд маань бол 1 малчин өрхийн орлого 50 сая, эрчимжүүлсэн мал аж ахуйн эрхэлж байгаа 1 өрхийн орлого 200 саяас дээш түвшинд байгаа.

Тэгэхээр бид нар энэ бэлчээр болон эрчимжүүлсэн мал аж ахуйг хослуулах тал дээр бол малчдад тодорхой хэмжээний олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд ч гэсэн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөдөө аж ахуйн яамтай хамтарсан хэлбэр дээр ч гэсэн маш их таниулах ажлуудыг эрчимжүүлсэн мал аж ахуйтай болох мөн бэлчээр, эрчимжүүлсэн хослуулснаар олох орлогын хэмжээ гэх мэтчилний тодорхой хэмжээний уулзалтуудыг, ярилцлагуудыг тодорхой бодит нөхцөл байдлуудыг танилцуулсан олон ажлуудыг бас Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хийгээд явж байгаа.

Өнөөдөр гол нөхцөл байдал маань бол яг ний нуугүй хэлэхэд уурхай гэхээс илүүтэй хамгийн их бэлчээрийн талхалт үүсэж байгаа нь бол мал аж ахуй, дээрээс нь хөрсний доройтол, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай холбоо бүхий асуудал байгаа. Би түүрүүн хэлсэн цэвдэгтэй холбоо бүхий асуудал. Өнөөдөр Монгол Улсад цэвдэггүй болсон 5 аймаг байна. Цэвдэггүй болохоор маш их хэмжээний цэвдгээ алдаж байгаа аймгуудын тоонд Баянхонгор аймаг орж байгаа. Бид нар цаашидаа хэрхэн цэвдгээ аварч хамгаалж авч үлдэх вэ гэдэг маань өөрөө “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй холбогдож байгаа.

Дээрээс нь булаг шандыг хамгаалах хэлбэрээр хөв цөөрөм

байгуулах, татан байгуулах гэх мэтчилний олон ажлууд бол бас төлөвлөгдөөд хийгдээд явж байгаа. 2023 онд гэхэд бид нар жишээлбэл, энэ бэлчээрийн доройтлоос урьдчилан сэргийлэх, хөв цөөрмийг байгуулах хэлбэр дээр бид нар нийтдээ 9 хөв цөөрмийг байгуулсан. 2024 оны улсын төсөв дээр бас тодорхой хэмжээний төсвүүдийг бол бид нар энэ хөв, цөөрөм байгуулах хэлбэр дээр бас тавиад явж байгаа.

Цаашидаа бид нар дорвитой арга хэмжээ авахын тулд ялт ч байхгүй энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам хамтран ажиллахаас өөр аргагүй ийм хэлбэр дээр байгаа гэдгийг би хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ “Тэрбум мод”, мод тарих хөдөлгөөн дээр би бас зарчмын хувьд бараг тэр философийнхоо хувьд нэг юман дээр жаахан зөрөө байр суурьтай байдаг юм. Ер нь энэ аливаа ийм том хөдөлгөөн, урт хугацааны ийм ажлын цаана эдийн засгийн утгаа л зөв тодорхойлохгүй бол баахан хандив тусламж, төр хувийн хэвшил баахан юм болоод мод тарьдаг. Яг үнэндээ эдийн засгийн утгатай, үүнийг тарьснаараа ашигтай, цаашид энэ яг тасралтгүй яаж явах юм гэдэг энэ схемээ бодохгүй бол баахан мод тарих тухай яриа, мод тарина гэдэг чинь зөвхөн шинжлэх ухаанч асар олон ажлын нэг л хэсэг нь. Тарина, арчилна, ургуулна, тэр нь тогтвортой ой болох гэдэг асуудал үүний цаана уг нь хүсэл, мөрөөдөл нь байгаа байх.

Гэтэл эдийн засгийн утга үүний цаана яг энэ ажил хариуцаж байгаа хүний хувьд тэр дээрээ тодорхой мэдээлэл өгөөч. Яг эдийн засгийн утга нь энэ модыг тарьснаар яг ямар ашиг тустай, ямар эдийн засгийн ашигтай юм? Ингэхгүй л бол энэ уриа лоозон болоод л өнгөрнө гэж. Жишээ нь миний санал бол магадгүй Сэлэнгэ аймагт Монгол Улсын бараг энэ картон цаас үйлдвэрлэлийн кластер төвийг тэнд бий болгох, тэнд асар их том талбайд мод тариалах, тэр мод тариалсан талбайгаараа үйлдвэрлэлийн түүхий эд болох тэрүүгээр дараагийн бүтээгдэхүүн хийх, үйлдвэр аж ахуйн газар тэнд ажиллах, импорт нь багасах, үүний цаана ажлын байр, үүний цаана орлого, үүний цаана эдийн засаг бий болж байж энэ чинь тэр мод чинь харин тогтвортойгоор олон 10 дахин нэмэгдээд явах юм биш үү? Тэрнээс зүг зүгт баахан мод тариалаад, янз бүрийн санал санаачилгуудаар хандив дэмжлэгээр тариалаад, энэ тэгээд маргааши үнэндээ л байхгүй шүү дээ.

Тэгэхээр үүн дээр ер нь байр суурь болоод бодлогынхоо чиглэлийг хэлж өгөөч. Сая тэр танилцуулга дээр хэлж байгаагаар бүтэн жилдээ Монгол Улс ойн салбараас 5 тэрбум төгрөгийн орлого олдог болдог гэж байна л даа. Тэгэхээр энэ юм чинь үнэ цэнгүй. Үүнийг ашигладаггүй, ашиглахгүй бол хайрлахгүй, ашиглахгүй бол энэнд дараа дараагийн хөрөнгө оруулалт орохгүй. Тэгэхээр энэ схемийг л нөгөө талаас нь хараач л гэж би бол тийм л хувийн байр суурьтай байдаг. Тэгэхээр үүн дээр бодлогын чиглэлүүдээсээ бас хэлж өгөөч.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд 83.

Б.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн маань үндсэн утга агуулга нь өөрөө эдийн засаг. Энэ утга агуулга өөрөө юу вэ гэхээр зөвхөн мод тариад ургуулаад дуусахтай холбоо бүхий асуудал биш. Өнөөдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн конвенцын талуудын 28 дугаар Бага хурал дөнгөж уржигдархан Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо болж дууслаа. Карбон маркет буюу энэ хүлэмжийн ялгарлын зах зээл өөрөө 234 тэрбум ам.долларт хүрчихсэн байгаа юм. Монгол Улс үүнд хэрхэн оролцох вэ гэдэгтэй холбоо бүхий асуудал.

Өөрөөр хэлбэл “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн гэдэг бол цаанаа тэрбумаар тоологдох модноос гадна тэрбумаар тоологдох ам.долларын эдийн засгийн эргэлтийг бий болгохтой холбоо бүхий асуудал. Энэ бол таны харж байгаа өнцөг бол маш зөв. Манайх байгаль орчны салбар дээр энэ хөрсний доройтол бусад бүх асуудлуудаа байгаль орчин дээрээ шийдвэрлээд явъя гэвэл Монгол улсад 11 тэрбум доллар шаардлагатай. Бид нар 11 тэрбум долларыг өнөөдөр төсвөөс гаргах ямар ч боломжгүй.

Тийм учраас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнөөр дамжуулж байгаль орчныг хамгаалах томоохон үйл ажиллагааг, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоо бүхий асуудлууд явж байгаа юм. Ойн менежмент рүү шилжүүлэх ёстой. Үүн дээр би тантай санал нэг байгаа. Ойн тухай хуульд намрын чуулганд өргөн барихаар бэлтгэл ажил хангаад, шинэчилсэн найруулгын төсөл бэлэн болсон байгаа. Энэ дээр ойн менежменттэй холбоо бүхий асуудлууд

хөндөгдөж байгаа. Тухайлбал, агро ойн аж ахуйтай холбоотой асуудлууд энэ дээр хөндөгдөж байна. Нөгөө карбон маркет буюу хүлэмжийн зах зээл дээр 1 мод тутмаас орох орлогыг тухайн модыг тарьсан хүн болгонд олон улсын зах зээлээс олж ирж авчрахтай холбоо бүхий асуудлуудыг хөндөж байгаа. Түрүүн Ганбат гишүүн бас хөндсөн утаатай холбоотой асуудал.

Тухайлбал гэр хороололд байгаа 1 айлын зөвхөн сэргээгдэх эрчим хүчээр тухайн айл бүх эрчим хүчнийхээ асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд жилдээ 2 мянган ам.долларыг орлого болгож авах олон улсын зах зээл дээр бас орлого болгож авах ийм боломж байгаа. Үүнийг бол бид нар бас Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй хамтраад ажиллаад явж байгаа. Яг үүнтэй адилхан карбон “Тэрбум мод” гэдэг энэ бол нэг утга агуулгатай юм гэдгийг бас хэлэхийг хүсэж байна. Агро ойн аж ахуй түрүүн би бас хэлсэн 452 мод үржүүлгийн газар. Энэ 452 мод үржүүлгийн газар эдийн засгийн эргэлтэд орсноороо илүү магадгүй 4000 болох ёстой. Нөгөө бизнесийн хэлбэр дээр энэ өөрөө бизнес эрхлэгчдийн тоо энэ дээр нэмэгдэх ёстой. Өнөөдөр 452 мод үржүүлгийн газар явж байгаагаас 76 иргэн, 25 нөхөрлөл 351 аж ахуйн нэгж байгууллага байгаа. Энэ тоог бид нар нэмэгдүүлэхийн төлөө явж байгаа. Тэрбумаар тоологдох модыг тооцож үзэх юм бол 1 жилд бид нар 330 саяас 150 сая ширхэг тарьц суулгасан хэрэгтэй байгаа. Бид нар өнөөдөр энэ тоог гүйцээхийн тулд явсаар байгаад дөнгөж 61 сая дээр л ирж байна. 61 сая дээр. Магадгүй 24 онд энэ тоо бид нарын урьдчилсан байдлаар гаргаж байгаагаар бол 120 сая дайна гэдэг ийм тооцоолоттой бид нар тооцож байгаа.

Ойн холбоо бүхий асуудал дээр өнөөдөр тогтолцооны асуудлыг бид нар хөндөхөөс өөр аргагүй байгаа. Жишээлбэл, ойн анги, сум дундын ойн анги маань бүгдээрээ аймагтаа харьяалагддаг. Аймгийн удирдлагаас томилогддог, аймгийн төсөв дотор буюу орон нутгийн төсөвт хөрөнгө, төсөвт байгууллага дотор явдаг. Тэгэхээр бид нар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр ашигтай явуулахын тулд нөгөө талдаа эдийн засгийн утга агуулгыг явуулахын тулд ч гэсэн ойн энэ ангиудыг бид нар Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд, харьяанд шууд оруулах энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж бид нар үзэж байгаа.

5 тэрбум төгрөгтэй холбоо бүхий асуудал хөндлөө. Ойн баялаг. Энэ бол зөвхөн мод өөрөөр хэлбэл бид нарын ярьдгаар гоожин. Энэ тоог бид нар яагаад их байхгүй байгаа юм бэ гэдэг дээр жишээлэх юм бол самартай холбоотой асуудал энэ дээр холбогдоогүй, бусад ургамал, жимстэй холбоотой асуудлууд энэ дотор холбогдоогүй, ойн дагалдах баялагтай холбоо бүхий асуудлуудыг нийтэд нь аваад үзэх юм бол энэ нь дандаа орон нутагтаа өөрөө ордог, тухайн сумдаа, аймагтаа ордог ийм мөнгөнүүд байгаа юм. Энэ тоо бол 18.5 орчим тэрбум төгрөг байгаа. Бид нар цаашидаа мод бэлтгэлийг аль болох унасан, үхсэн.

Жишээлбэл, ой хээрийн түймэрт өртсөн, ой хөнөөлт шавжид нэрвэгдсэн. Энэ тоо судалгаануудыг бол бид нар бүгдийг нь 2022 ондоо багтааж. Яг өнөөдөр байгаа тооцоо, судалгаагаар бол бид нар унасан болон үхсэн энэ моднуудыг бүгдийг нь тооцоод үзэхэд бид нарт Монгол Улсын 3.5 сая

иргэнээрээ тооцоход 60 жилийн нөөц байна 60 жилийн нөөц. Уржигдар, өчигдөр гээд бас Бага тэнгэрийн амнаас мод бэлтгэлтэй холбоотой шүүмжлэлүүд яваад байх шиг байна. Энэ бол Их тэнгэрээс эхэлсэн ойн цэвэрлэгээтэй холбоотой ажлууд явж байгаа. Бага тэнгэр, Их тэнгэр, Залаат, Чулуут, дараагийн амнууд руугаа бид нар үргэлжлээд явна гэдэг ийм тооцоо, судалгаагаар явж байгаа. Энэ бол.../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт. Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” хөтөлбөрийг дэмжиж байгаа юм. Бас олон улсын тавцанд цөлжилттэй тэмцэх тэр Монгол Улсын нэрийг өргөсөн сайхан хөтөлбөр. Энэ хүрээнд аймгууд, дүүргүүдэд хэчнээн хэмжээний мод үржүүлгийн газар байна, хэчнээн мянган мод үржүүлж байна энэ талаар асууя.

Хоёрдугаарт энэ Ачит нуурын сав газарт хуучин Ногоон нуурын тэжээлийн аж ахуй байсан малын тэжээлийн ургамал тариалах талаар бодож байгаа бодол байна уу? Энэ цаашидаа хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ямар бодолтой байна?

Хоёрдугаарт энэ Баяннуур сум нөгөө Эрдэнэбүрэний усан цахилгаан станцтай холбоотой 300-аад айл өрхийн хадлан усанд автах юутай байгаа. Үүнийг цаашидаа яаж шийдэх вэ? 300 малчин айл өрхийн хадланг яаж шийдэх гэж байна? Мөн тусгай хамгаалалттай газарт отрын асуудал байгаа. Баян-Өлгий аймгийн Булган сум цас маш их орсон, нойтон чийг орсон, 10 суурь мал

Хөх сэрхий нуруу, Дунд гол гээд тусгай хамгаалалттай газарт очоод сар болж байгаа. Ховд аймгийн Ховд сумын Засаг даргатай зөвшилцөөд очсон байна лээ.

Гэтэл энэ тусгай хамгаалалттай газрын байцаагчид 3 сая төгрөгийн торгууль тавиад л буцаж яв гээд хөөж байгаа юм байна. Буцах зам, мал явах замгүй цастай. Нөгөө талаар өнөөдөр бас нэмж цас орж байна гэнэ. Очиход бас бэлчих газар байхгүй. Энэ асуудлыг сайд минь яаралтай шийдэж өгөхгүй бол түрүүн Онцгой комиссын дарга, Шадар сайд, Их Хурлын даргад хүртэл хэлсэн. Энэ асуудлыг яаж шийдэх вэ? Малчид ноднингийн тэжээл өвснийхөө зээлээс одоог хүртэл салаагүй байгаа шүү дээ. Үүнийг яаж шийдэх гэж байна та?

Г.Занданшатар: 83.

Б.Бат-Эрдэнэ: Бейсен гишүүний асуултад хариулъя. Дийлэнхдээ дандаа бэлчээртэй холбоотой асуудлууд хөндлөө. Эхний асуулт болох 452 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж байгаа. Энд бол нийтдээ 62 сая орчим тарьц, суулгац бэлтгэгдэж байгаа. Энэ бол өнгөрсөн жилийг харьцуулах юм бол 5 дахин өссөн үзүүлэлт. Бид нар цаашидаа 2024 онд гэхэд 120 сая гээд нэмэгдээд явна. Энэ болгон бол тухайн мод үржүүлгийн чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдэд орлого болж орох ийм боломж юм байгаа юм.

Баян-Өлгий аймгийн хувьд бол өнгөрсөн хугацаанд нийтдээ 382871 ширхэг модыг тарьж ургуулсан. 2023 оны хувьд бол 167821 ширхэг модыг тарьж ургуулсан. Үүнийг бол дан ганц аймаг бас тариад байгаа юм биш мод үржүүлгийн иргэн, аж ахуйн нэгжүүд

бол энд бас тарьж байгаа. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийслэл аймгууд нийтдээ бас амлалт авсан тоо хэмжээнүүд гэж бий. Үүний хүрээнд бол Баян-Өлгий аймаг маань бас тодорхой хэмжээний моднуудаа тариад явж байгаа.

Бэлчээртэй холбоотой асуудлууд хүндэрч байгаа. Энэ цаашидаа хүндэрнэ. Яагаад гэвэл 1990 оноос өмнөх гарсан бэлчээрийн даацын судалгаагаар 25 сая малын даацын бэлчээртэй юм байна лээ. Өнөөдөр Монгол Улс 71 сая малын бэлчээр ашиглагдаж байна. Түрүүн хэлсэнчлэн ургамал, өвс үрээ цацаж амжихгүй байна. Үрээ цацаж амжихгүй байна. Тэгэхээр бид нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай ярилцаад энэ асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө явж байгаа. Тухайлбал, түрүүний хэлсэнчлэн бэлчээр болон эрчимжүүлсэн мал аж ахуйг бид хосолмол хэлбэр рүү бид нар зайлшгүй шилжихээс өөр шаардлага, шилжихээс өөр арга байхгүй гэдэг ийм хэлбэр дээр явж байгаа.

Баян-Өлгий аймаг, Булганд цас их орсон. Энэ жил өвөлжилтийн байдал ялангуяа цасны хэм хэмжээ нэмэгдэхээр байгаа. Зөвхөн энэ жил биш, цаашидаа жилд орох цасны хэмжээ өдрийн хэмжээгээрээ тооцвол ихэснэ, бүүр ихэснэ. Энэ бол олон улсын түвшинд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулааралтай холбоо бүхий гарсан тооцоо судалгаанаас үндэслэж би бас та бүхэндээ хэлж байгаа тоо юм шүү гэдгийг бас хэлье.

Малын бэлчээртэй холбоо бүхий асуудал бид нар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа. Энэ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай

хууль өөрчлөлт орж байж энэ асуудлууд нэг талдаа шийдвэрлэгдэнэ. Өнөөдөр Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль дээр заасан хуулийн дагуу хэрэгжүүлэх байдал дээр л Байгаль орчин, аялал жуулчлалын яам гүйцэтгэл дээр л бид нар ажиллаж байгаа. Өнөөдөр хууль нь ийм, хууль нь ийм учраас Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаадын албан хаагчид буюу байгаль хамгаалагч нар хуулийн дагуу л арга хэмжээг авч байгаа юм. Та бүхэн санаж байгаа бол өнгөрсөн жилийн яг энэ асуудал Сэлэнгэ аймаг дээр хөндөгдсөн. Сэлэнгэ аймаг дээр хөндөгдсөн энэ асуудал дээр бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам хатуу байр суурьтай байсан. Бид нар хуулиа мөрдөж ажиллана, өөр арга бид нар цаашидаа байхгүй. Эсвэл хуулиа өөрчлөх ийм эрх зүйн өөрчлөлтийг л бид нар хийхээс өөр аргагүй хэлбэртэй байгаа шүү гэдгийг ярьж байгаа.

Үүний дагуу ч гэсэн Байнгын хороонууд дээр ялангуяа манай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон дээр энэ асуудлууд хэд хэдэн удаа яригдсан, устай холбоо бүхий асуудлууд яригдсан, Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалттай холбоо бүхий асуудлууд яригдсан. Нийт Монгол Улсын газар нутгийн 21 хувь буюу өнөөгийн Польш улсын газар нутагтай тэнцэх хэмжээний газар нутаг өнөөдөр 32.8 сая га талбай бол тусгай хамгаалалтад байна. 2030 он гэхэд бид нар 30 хувьд хүргэх ёстой. 30 хувьд хүргэхэд хамгийн их хөндөгдөх сэдэв бол бэлчээр, хөрсний асуудал.

Гэтэл нөгөө талдаа бид нар ирээдүйн 70 жилийн хугацаанд ахиад цэвдгийнхээ 40 орчим хувийг алдахаар тооцоо судалгаа гарч байна. Мөстлөгт

километр квадрат газар нутгаар бид нар хэмждэг. Километр квадратаар нь тооцоход 1940 он, 2022 оны хооронд бид нар 200км квадрат газар нутгийг бид нар мөстлөг дээрээ алдчихаад байна. Дэлхийн дулаарлаас улбаатай бид нар маш их хэмжээний мөнх цасаа бид нар алдаж байна. Энэ маань өөрөө юунд нөлөөлж байгаа вэ гэхээр эргээд нөгөө бэлчээрт нөлөөлдөг асуудлууд, эргээд хөрсөнд нөлөөлдөг асуудлууд.

Тэгэхээр байгаль орчны асуудал гэдэг бол цогцоороо яригдахаас дан багаараа Байгаль орчин, аялал жуулчлалын яам шууд шийдвэрлээд явчих ийм боломжгүй ийм асуудал. Тэр утга, агуулгынхаа хүрээнд бол бид нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хосолмол бэлчээр болон эрчимжүүлсэн мал аж ахуйг хосолмол хэлбэрт аваачих, эргэн нөхөн сэргэх, өвс, ургамал үрээ цацах хэмжээг цаг хугацааг олох хэлбэр дээр бид нар газрыг газар тариалан шиг өнжүүлдэг хэлбэр рүү шилжүүлэхээс өөр аргагүй гэх мэтчилний ийм эрдэмтэн, судлаачдын ярьж байгаа маш олон асуудлуудыг бид нар бас авч үзээд судалгаа шинжилгээний хүрээнд бол эцсийн шийдвэрүүдийг бид нар гаргаад, тодорхой хууль, эрх зүйн хүрээнд өөрчлөлт оруулахаар ингээд ажил.../минут дуусав./

Г.Занданшатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшиээлтэй хүний хөгжлийн төвийн хамт олны төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэр тусгай хамгаалалттай газар очоод сар болж байгаа малчид байна шүү дээ. Тэр ноднингийн өр зээлээсээ салаагүй, 3 сая төгрөгийн торгууль тавьж байгаа юм байна. Үүнийг бас шийдээж өгөхгүй бол ерөөсөө төлөх мөнгө ч байхгүй малаа бараг нэлээн турчихсан хүнд байдалтай буцаж яах боломжгүй юм байна шүү дээ. Үүнийг Онцгой байдалтай ярьж байгаад та үүнийг шийдэх, таны эрх хэмжээний хүрээнд шийдэх асуудал юм байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт тэр Ачит нуурын сав газрын хуучин Ногоон нуурын тэжээлийн аж ахуйд байхдаа малын тэжээл тариалж байсан байна. Үүнийг цаашидаа сэргэх үү? Нөгөө талаар бас Таван салаагийн ус та мэдээж байгаа. Тэр ус татаад бас тэр цөлжиж байгаа талбайг нь дахиж нөхөн сэргээх боломж байгаа юм байна. Энэ талаар баримталж байгаа бодлого байна уу гээд асуусан дээрээс нь.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд 83.

Б.Бат-Эрдэнэ: Ачит нуурын тэжээлийн аж ахуйтай холбоотой асуудлыг бид нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай ярья. Манай Байгаль орчин, аялал жуулчлалын яам дээр энэ тэжээлийн аж ахуйтай холбоотой мэдээлэл байхгүй байна.

3 сая төгрөгийн торгууль тавьсан. Энэ торгуулийн асуудлууд бол

шүүхээр шийдвэрлэгдэх байх. Үүнийг шууд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хуулийн дагуу байгаль хамгаалагч нар торгууль хуулийн зөрчил гэж тавьж байхад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд шууд хүчингүй болгох эрх зүйн чадамж өнөөдөр Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу байхгүй.

Хоёрдугаарт энэ бол эрх мэдэл албан тушаалын асуудал болж хувирна. Тэр утга агуулгынхаа хүрээнд бол энэ тавьсан торгуультай холбоо бүхий асуудал бол шүүхээрээ шийдвэрлэгдээд явах байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу намын бүлгүүдийг төлөөлж ард иргэдээ *d.parliament* цахим системээр дамжуулж ирсэн өргөдөл, цахимын дагуу хэлэлцэнэ. Ингээд мэтгэлцээн өрнүүлнэ.Одоо Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэг асуулт асууна.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр Монгол орны ойн сангийн төлөв байдал мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд Бат-Эрдэнийн мэдээллийг сонслоо.

Тэгэхээр энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг бас Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилсан нь өнөөдөр Монголд төдийгүй дэлхийд бас уриалсан ийм том хөдөлгөөн болсон. Энэ хөдөлгөөнд ганц мод тарьж ургуулах биш цаашидаа бид нар байгаа модоо

арчилж хамгаалах, нөхөн сэргээх гээд маш олон ажлууд орж байгаа.

Үүнээс хойш бол бас Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр Ойн газар гэсэн том агентлаг байгуулагдаад мэргэжлийн хүн удирдаад, бас мэргэжлийн хүмүүс ажиллаж байгааг бас хараад бас энэ хамтын ажиллагаа, төр хувийн хэвшлийг нэмэгдүүлэхийн төлөө бас ажиллаж байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай мэдээлэлтэй холбогдуулж бас энэ *d.parliament* цахим сайтад иргэдээс ирүүлсэн асуултуудыг нэгтгэн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж асууя.

Тэгэхээр иргэдээс бас дараах асуултууд ирсэн байна. 2023 оны 1 сараас эхлэн энэ мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байсан аж ахуйн нэгжүүд НӨАТ төлөөд эхэлчихсэн. Үүний өмнө бас Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгч байх үедээ бас санаачлаад яг энэ Байгаль орчны яам хамтраад энэ НӨАТ-аас чөлөөлж байсан. Энэ чөлөөлөлт нь бас ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд маш их хувь нэмэр оруулж байсан.

Тэгэхээр энэ одоо НӨАТ төлөгдөөд эхэлчихсэн энэ үед Засгийн газар салбарын яам ямар бодолтой байгаа вэ, ямар арга хэмжээ авч байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Дараагийн асуулт Монгол Улсад 62 сая мод, үржүүлсэн мод, тарьц, суулгац байна гэж бас сайд ч хэлсэн, энэ иргэдээс ч ирсэн байна. Тэгэхээр мод суулгацыг 2-3 жилийн дотор талбайгаа чөлөөлж шилжүүлэн суулгах хэрэгтэй байдаг тул эдгээрийг борлуулахад энэ аж

ахуй нэгжүүдээ дэмжих тал дээр ямар бодлого хэрэгжүүлж байна вэ?

Дараагийн 1 асуулт энэ “Тэрбум мод” тарих хөдөлгөөний хүрээнд томоохон уурхайнууд энэ хөдөлгөөнүүдийг бас дэмжиж ажиллах бас амлалууд өгсөн. Тэгэхээр үүний дагуу энэ томоохон компаниудыг мэргэж ажлын мод тарих, байгууллагуудтай холбон хамтран ажиллуулах тал дээр бас яаж анхаарч ажиллаж байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Ойн хортон устгах ажил яг тухайн хортны устгах зөв үе шатад нь хийгдэж байна уу? Энэ дээр ямар байгууллага хяналт тавьж байна вэ? Хортон устгах ажлын үр дүн ямар байгаа вэ гэсэн дээр хариулт өгөөч.

Ойн тухай хуулийн 4 дүгээр бүлэг дээр энэ ойн нөхөрлөл байгуулах гэсэн ийм заалт байгаа. Тэгэхээр үүний хэрэгжилт ямар байгаа вэ? Хэдэн нөхөрлөл ажиллаж, энэ хэдэн бас нөхөрлөл ажилласнаараа энэ төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангаж байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Сүүлийн асуулт бол Сонгинохайрхан дүүрэгт Гүнжийн нуур, Хунт нуур хоёр нуур бас хамгаалагдах, цэвэрлэх зайлиггүй шаардлагатай байгаа. Энэ тал дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ гэсэн ийм асуултууд байна.

Ер нь энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бол ганц салбарын яамны ажил биш. Энэ салбар дундын хамтын ажиллагаа байгаа. Тэгэхээр энэ хамтын ажиллагааг хангах тал дээр бас салбарын сайд, Ойн газар бас хамтран

бас манлайлж ажиллаж байгааг бас онцлон хэлэхийг хүсэж байна. Тэгээд эдгээр асуултад хариулахдаа Улсын Их Хурлын баталсан Ойн тухай хуулийн хэрэгжилт болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн дагуу байгуулсан энэ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын үйл ажиллагаатай холбож хариулахыг хүсэж байна. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Саранчимэг гишүүний асуултад иүүд хариулаад явчих уу даргаа?

Л.Мөнхбаатар: Тэг Бат-Эрдэнэ сайд иүүд хариултаа явчих. Таны микрофоныг нээчихсэн. Асуулт, хариулт хоорондоо иүүд явж болно.

Б.Бат-Эрдэнэ: Ойлголоо.

Л.Мөнхбаатар: Нийт хугацаа 20 минут тийм.

Б.Бат-Эрдэнэ: Саранчимэг гишүүний асуултад хариулья. 2023 оны 1 дүгээр сараас эхлээд НӨАТ төлөөд эхэлчихсэн явж байгаа. Энэ дээр бол мод, модон материалтай холбоо бүхий асуудлууд хөндөгдөж байгаа. Үүнийг бол бид нар бас Сангийн яамтай, Ерөнхийлөгчийн Тамгын газартай энэ асуудлыг бол ярилцаж байгаа. Яг одоогийн байдлаар эцэслэгдэн гарсан үр дүн бол мэдээлэхэд боломжгүй байна. Ер нь бол Сангийн яаманд хэд хэдэн удаагийн энэ НӨАТ-ыг болиулахтай холбоо бүхий асуудлыг хөндсөн. Ер нь бол НӨАТ гэдэг бол гинжин татвар. Бид нар татварын тодорхой бодлогын хүрээнд бол оролцоод байх бас боломж юу байна гэдэг утга, агуулгын асуудлууд бас нөгөө талдаа хөндөгдөөд байгаа юм. Тэгэхээр энэ бол тодорхой хэмжээнд үр дүнд

хүрчих байх гэж бодож байгаа.
Хоёрдугаарт.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Микрофоноо Бат-Эрдэнэ сайдынхыг, Саранчимэг гишүүн хоёрынхыг нээчих. Нийт хугацаа 20 минут. Бие биеэсээ асуултаа тавиад, хариулаад явчхаж болно. Ажлын хэсгээс нэмж хариульа гэсэн юм уу?

Б.Бат-Эрдэнэ: Үгүй энэ сая микрофон нь унтарчихлаа.

Л.Мөнхбаатар: Одоо ингээд нээчхэж байгаа. Бие биедээ асуултаа шууд тавиад явчихъя.

Б.Бат-Эрдэнэ: Хоёрдугаар асуулт 62 сая тарьц, суулгацтай холбоо бүхий асуудал. Бид нар бол мод үржүүлгийн бизнест орж байгаа иргэдийн тоо, аж ахуйн нэгжүүдийн тоог аль болох нэмэгдүүлэх шаардлагатай. Ингээж байж эдийн эдийн засгийн эргэлт бий болно. Энэ утга агуулгынхаа хүрээнд бол аймаг болгонд нийслэл, дүүргүүдэд, дүүрэг ч их айхтар орохгүй дээ. Нийслэлд, аймгуудад бол бид нар 20, 20 га газар мод үржүүлгийн компаниудад гаргаж өгөх ёстой гэдэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал, сүүлд бол бүүр албан даалгавар болж очсон байгаа. Зарим аймгууд маань бол үүнийг хэрэгжүүлээд эхэлчихсэн явж байгаа.

Жишээлэх юм бол Төв аймгаас авхуулаад, Орхон аймгаас авхуулаад тодорхой аймгууд маань үүнийг хэрэгжүүлээд эхэлчихсэн явж байгаа. Тэгэхээр энэ ажил бол цаашдаа үргэлжлээд явна. modlog.mn гээд цахим хэлбэрт бид нар шилжүүлсэн. Цахим арилжааны бирж, өөрөөр хэлбэл “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц, суулгац бэлдсэн иргэд

маань өөрсдөө modlog.mn рүүгээ ороод тарьц, суулгацынхаа худалдаалах үнэ тариф, модныхоо зураг, хэмжээ, бүх мэдээллийг оруулах боломжтой.

Нөгөө талаас нь бол худалдан авагч тал modlog.mn рүү ороод өөрсдөө таарах, тохирох модыг шууд худалдаад авах боломжтой. Ийм арилжааны биржийн системийг бол “Ай Си Ти” групптэй хамтраад Байгаль орчин, аялал жуулчлалын яам, агентлаг хэрэгжүүлээд эхэлчихсэн энэ бол явагдаж байгаа.

Гуравдугаар асуулт бол уул уурхайн салбарынхантай холбоо бүхий асуудал дээр бол бид нар хэд хэдэн удаагийн уулзалт холбоосуудыг бид нар хийж өгөөд ажиллаж байна. Тухайлах юм бол Богд хан ууланд бид нар 2 сая мод тарьж ургуулах шийдвэрийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын зүгээс гаргаж, үүн дээр бол Уул уурхайн компаниуд хариуцлагын хүрээнд, нийгмийн хариуцлагын хүрээнд бол тухайн тарьж ургуулах амлалтынхаа амлалтынхаа хүрээнд тухайн моднуудыг тарих ажлуудыг эхлүүлчхээд явж байгаа. Үүн дээр бол жишээлэх юм бол Эрдэнэт үйлдвэрийг бид нар хэлж болно. Эрдэнэт үйлдвэр 1 сая модыг Богд Хан ууланд тарьж ургуулна гэдэг ийм амлалт аваад, тодорхой ажлууд нь эхэлчихсэн явж байх жишээтэй байгаа.

Дээрээс нь бид нар энд бол ялт ч байхгүй “Оюу толгой” буюу “Рио Тинто” Монгол компанийг дурдахаас өөр арга байхгүй. Яагаад гэхлээр “Оюу толгой” компани бол 100 сая мод тарьж ургуулна гэдэг ийм амлалтыг авсан. Үүний хүрээнд бол нөхөн сэргээлт Сэлэнгэ аймаг Ерөө сумын Ялбагийн гол дээр 387 га талбайг нөхөн сэргээсэн. Энэ га талбайг бол 5.7 сая ширхэг модоор

дүйцүүлж нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явагдсан. Энд бол хувийн хэвшлийг дайчилж оруулсан байгаа. Тарьж байгаа. Энэ жил бол мод таригдах ёстой. Энэ жил Дарханы домогт Шарын гол дээр үлдсэн 187 га нөхөн сэргээлтэд социализмаас өмнө орхигдчихсон байсан энэ талбайг бол нөхөн сэргээлт ажиллаад, мөн “Рио тинто” Монгол компанитай бид нар “Оюу толгой” компанитай хамтраад ажиллаад явж байгаа.

Дээрээс нь техникжүүлэх буюу механикжуулах ажлуудыг бол тодорхой хүрээнд бол бас уул уурхайн компаниудтай хамтын ажиллагааны хүрээнд худалдан авах ажиллагааны түвшинд зохион байгуулалтуудыг бол хийгээд явж байна.

Ойн хөнөөлт шавжтай холбоо бүхий асуудал. 2023 онд бас Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүддээ талархал илэрхийлэх ёстой. Улсын төсөв дээр тодорхой төсвийг тавьж өгсөн. Дээрээс нь аймгууд, орон нутгийн төсөв, мөн “Рио Тинто” компанитай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ агуулга бол орсон. Үүний хүрээнд бол бид нар нийтдээ 270 мянга орчим га талбай дээрх голомтлогдсон талбайн энэ ой хөнөөлт шавжтай тэмцэх ажлуудыг бол бид нар хийж дуусгасан байгаа. Нийтдээ 1 тэрбум модыг бол бид нар ой хөнөөлт шавжид нэрвэгдэж мөхөхөөс, үхэхээс хамгаалсан гэсэн үг.

Нийт 2023 онд гарсан тооцоо судалгаагаар бол 735 мянган га талбай бол ой хөнөөлт шавж голомтлогдсон талбайгаар нэрлэгдэж байгаа. Үүнээс

бол бид нар 270 орчим мянган га талбайг бол хийж дуусгасан гэсэн үг.

2024 оны улсын төсөв дээр бол бид нар энэ ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг бол эрчимжүүлэх хүрээнд төсвийг бол нэлээн өндөр хэмжээнд тавьж өгсөн.

Хоёрдугаарт бол Улсын ерөнхий прокурортой өнгөрсөн жил хэрэгжүүлж байсан буюу Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт буюу ойн дагалт баялаг ашигласан, эргээд 85 хувиар зарцуулагдах ёстой. Энэ мөнгө бол ойн хөнөөлт шавж дээр зарцуулагддаг. Үүнийг аймаг, сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлагууд хууль бус зарцуулалт хийсэнтэй холбоо бүхий асуудлууд хөндөгдөж байгаа. 2022 онд бид нар Авлигатай тэмцэх газартай хамтран ажилласан 3 удаагийн томоохон арга хэмжээг бид нар авч хэрэгжүүлсэн байдаг. Үүний хүрээнд 2021 онд 21 хувьтай байсан хэрэгжилт бол 2022 онд 43 хувьтай болсон. 23 онд бид нар Улсын ерөнхий прокурортой хамтарч ажиллаж байгаа, прокурорын байгууллагатай хамтарч ажиллаж байгаа. Үүний хүрээнд урьдчилсан тооцооллоор бол 2023 оны дүгнэлт бол 80 орчим хувьтай гарна гэдэг ийм тооцоо, дүгнэлтүүд бол урьдчилсан байдлаар гарч байгаа.

Тэгэхдээ дүгнэлтийг гарсны дараагаар бид нар бас эцэслэн мэдээлэх хэлэх ёстой. Энэ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт бол хэрэгжих ёстой, эргээд ойдоо зарцуулагдах ёстой гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Ойн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн нөхөрлөлтэй холбоо бүхий

асуудал. Өнөөдөр нийтдээ 452 мод үржүүлгийн газар ажиллаж байгаагаас 25 нөхөрлөл нөхөрлөлийн хэлбэр дээр ажиллаж байгаа. Бид, тийм би хариулчих уу? Нөхөрлөлтэй холбоо бүхий асуудлыг бид нар Ойн тухай хуульд аль болох энэ менежментийн хэлбэрийг бид нар цаашидаа авч явах, илүү дэлгэрүүлэх хэлбэр дээр бид нар ойн нөхөрлөлийг маш чухалчилж байгаа. Тэгэхээр ойн нөхөрлөлүүдийн тоог бол бид нар хуульд өөрчлөлт орсноор илүү их эдийн засгийн тооцоолол хэлбэр рүүгээ ороод явна. Энэ өөрөө нөхөрлөл гэдэг маань бол гол энэ модыг тарьж, ургуулах, ойн дагалдах баялгийг зохицуулалтыг хийж байх, нөгөө унасан мод, ургаа мөртөө үхсэн модыг эдийн засгийн эргэлтэд оруулж байх холбоо бүхий асуудлыг бол хийж явж байх газрыг бол бид нар ойн нөхөрлөл гэж бид нар бас үзэж байгаа.

Гүнжийн нууртай холбоотой асуудал, усны бохирдолтой холбоо бүхий асуудал яг 2024 оны Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсөвт ороогүй. Үүнийг бол бид нар тэгэхдээ тухайн жижигхэн учраас тодорхой хэмжээнд бас бохирдлоос салгахтай холбоо бүхий асуудлыг сайдын шийдэх, эрхлэх асуудлын хүрээнд шийдээд явчих боломжтой болов уу гэж харж байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд баярлалаа. Тэгэхээр иргэдээс ирсэн асуултуудыг бас асуулаа. Мөн *d.parliament.mn* сайтад иргэн Халиунаас ирсэн хүсэлтийг бас танилцуулъя. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ШУТИС болон “Нэг бүс нэг зам” олон улсын хөгжлийн судалгааны академи хамтран Хятадын олон улсын оюутны нэрэмжит ой төслийг ШУТИС-ийн зураг төсөл, төлөвлөлтийн дагуу

боловсруулж 2024 оноос хэрэгжүүлж эхлэх гэж байна. Тэгэхээр энэ төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхийг хүсэж байгааг уламжилж өгнө үү гэсэн ийм санал байна. Энэ саналыг уламжилж байна.

Нөгөө талаар бид нар энэ 2023 оны 1 сараас эхлэн энэ мод үржүүлэг, цэцэрлэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд НӨАТ төлж эхэлсэн. Тэгэхээр энэ тал дээр бол Засгийн газар илүү их анхаарч ажиллах шаардлагатай байгаа юм.

Яагаад гэвэл өмнө нь нь ингээж чөлөөлснөөрөө ногоон байгууламж эрхэлдэг мод үржүүлгийн талбай, мод үржүүлэг эрхэлдэг ийм аж ахуйн нэгжүүдэд маш эерэг нөлөөтэй байсан. Тэд нар маань маш ихээр энэ мод тарьц, суулгацыг үйлдвэрлэж байсан. Одоо бол НӨАТ төлснөөр бас их сөрөг нөлөөтэй байна гэсэн. Тэгэхээр энэ дээр бол салбарын сайд илүү манлайлж ажиллаасай гэж хүсэж байна.

Нөгөө талаар энэ газар яг энэ мод үржүүлэг эрхэлж байгаа хүмүүст бас л нөгөө газрын дуудлага худалдаа аягүй их өндөр үнэтэй болчихоод, нөгөө хүмүүс чинь мод үржүүлэг энэ “Тэрбум мод” хөдөлгөөнд оролцох гээд ирэхээрээ бас хэн нэгэндээ бас эдийн засгийн өгөөжтэй байх ёстой байдаг. Гэтэл энэ газрын дуудлага худалдаа чинь үнэхээр бас хэцүү байна гээд байгаа. Энэ дээр асуулт, хариулт авъя. Цаашидаа бас энэ НӨАТ дээр хэзээ яг ийм энэ НӨАТ-гүй болгох бодлого хэрэгжиж чадах болов гэсэн энэ асуулт дээр тодорхой хариулт авъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа, дахин хариулъя. Халиунд хэлэхэд 24 оны төслөө аваад ирээд бид нар бас манай агентлаг

маань үзээд, судлаад хэрэгжүүлэх боломжтой төсөл байгаа тохиолдолд бид нар дэмжээд явчих бүрэн боломжтой. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн гэдэг ерөөсөө л иргэд, аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа бүх явуулж байгаа бүхий л байгууллагуудын санал, санаачилгыг бид нар дэмжих ёстой. Энэ утга, агуулгын хүрээнд бол дэмжих боломжтой. Төслөө авчирч үзүүлээрэй гэж хүсэж байна.

НӨАТ-тай холбоо бүхий асуудал дээр бид нар ажиллаж байгаа. Үүнийг бол 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс бас Сангийн яамнаас амжиж шийдвэр гаргуулахын төлөө бид нар хичээж ажиллая гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

Гуравдугаарт, Газрын дуудлага худалдаатай холбоо бүхий асуудал яах вэ энд зөрчилтэй нэг юм байгаа. Түрүүн би хэлсэн аймгууд дээр тухайлбал, 20 га газар гарга гээд. Аймаг дээр гаргаж байгаа 20 га газар бол ихэвчлэн угтах хаалганаасаа авхуулаад эхэлж байгаа. Үүнийг аймаг маань нэг шаардлага тавьж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр аймгийн Засаг даргын тамгын газрын нэр дээр байя. Та нар маань 3 жил мод үржүүлгийнхээ ажлыг ямарваа төлбөргүйгээр ирээд хийчих. Тарьц, суулгац мод үржүүлгийн компаниуд иргэн, аж ахуйн нэгж байгууллага хийчих. 3 жилийн дараагаас би хэдүүлээ асуудлуудаа өөрөөр шийдвэрлэж эхэлье. Өөрөөр хэлбэл та 3 жил тарьц, суулгац мод үржүүлгийн ажил хийчихсэн тохиолдолд танд тухайн газрыг өгөхтэй холбоо бүхий асуудлуудыг бид нар шийдвэрлэх боломжтой гэдэг энэ юмыг яриад байгаа юм. Мод үржүүлгийн зарим.

Б.Саранчимэг: Хууль дээрээ ямар байгаа юм, боломж юм байх юм уу?

Б.Бат-Эрдэнэ: Аймгийн Засаг даргын тамгын газрын нэр дээр байна гэдэг маань дуудлага худалдаанд орох шаардлагагүй л гэсэн үг. Тухайн иргэн, аж ахуйн нэгж байгууллага газар авах болоод эхэлбэл заавал хуулиараа дуудлага худалдаа болчихоод байгаа юм. Эзэмших, өмчлөх нь дуудлага худалдаа, ашиглах нь сонгон шалгаруулалт. Тийм тэгэхээр Газрын багц хууль Улсын Их Хуралд өргөн баригдана. Бид нар Газрын багц хуулийг дагалдуулаад Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль өргөн баригдахаар төлөвлөгдөж байгаа.

Дээрээс нь манай яамнаас бол Байгалийн ургамлын тухай хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль гэх мэтчилний хуулиуд, Генетик нөөцийн тухай хууль гээд хуулиудыг дагалдуулж өргөн барихаар бас бид нар төлөвлөөд явж байгаа. Тэгэхээр тухайн хуулиудын хоорондын нийцэл, эрх зүйн орчин дээр бол нэг байх ёстой тэр утга, агуулгынхаа хүрээнд бол уул нь бол бид нар бол аймгуудаас тавьж байгаа шаардлагыг манай Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зөв гэж үзэж байгаа юм.

Яагаад гэхлээр та мод үржүүлгийн газраа 3 жилийн хугацаанд тэндээ ямар ч төлбөр мөнгө төлөхгүйгээр хийчих. Тэгэхгүй бол зарим нь мод үржүүлгийн газар хийнэ гэдэг нэрээр магадгүй нөгөө аялал жуулчлалын бааз байгуулна гээд Богд Хан уулыг байшин хороолол болгосон шиг алдаа давтагдах вий. Тэгэхээр 3 жил ямарваа нэг төлбөр, мөнгөгүйгээр тухайн газар

нутаг дээр үйл ажиллагаа явуулах бүрэн эрхийг нь аймгуудаас нээж өгч байгаа учраас энэ хэлбэр нь яваг. 3 жилийн дараа үнэхээр тогтвортой үйл ажиллагаа явуулаад байвал тухайн газрыг эзэмшүүлэх, өмчлөх хэлбэр дээр нь бол тухайн аймгийн Засаг даргын Тамгын газраас өгчих бүрэн боломжтой гэж ийм шийдлүүд гаргаж байгаа учраас энэ шийдлийг бол бид нар зөв гэж харж байгаа.

Б.Саранчимэг: Тэгэхээр та түрүүн ярьж байсан одоо бол яг 62 сая мод тарьц, суулгац байна гэсэн. Тэгэхээр эдгээрийг борлуулахад бас аж ахуйн нэгжүүдээ дэмжихэд яаж ийм уялдаа холбоотой хамтарч ажиллаж байгаа вэ? Тэгэхээр бид нар өнөөдөр аягүй хуулиа л хэрэгжүүлдэг байх ёстой байхгүй юу. Үнэхээр мод үржүүлгийн талбайг ашиглаад өөрсдөө модоо үржүүлэх гэж байгаа хүмүүст та нар ингэчих вий, өөр байшин барилга барьчих вий гэдэг биш, үүнийгээ нөгөө иргэд нь ч өөрсдөө хэрэгжүүлдэг, яг төр нь ч гэсэн үүнийг бодлогоор дэмждэг баймаар байгаа юм.

Тэгэхээр энэ дээр ер нь цаашидаа бид нар мод үржүүлгийн талбайг маш ихээр бий болгож өөрсдөө, бусад оронд цэцэрлэгт хүрээлэн байгуулъя гэвэл шууд үржүүлгийнхээ талбайгаас л том том модууд зөөгөөд л авчраад тавьчихдаг шүү дээ. Ер нь ямар нэгэн цэцэрлэгт хүрээлэнг байгуулахад яг ийм бодлоготой явахгүй бол бид нар 1, 2 настай үржүүлгийн ийм жижигхэн тарьцууд суулгаад байх юм бол цаашидаа ч гэсэн энэ ногоон байгууламж бүүр цаашилбал цэцэрлэгт хүрээлэн байгуулах маш удааширалтай байх учраас үүн дээр бас яг эдгээрийг борлуулахад аж ахуйн нэгжүүдийг дэмжих тал дээрээ яг

тодорхой бодлогоо тодорхой хариулна уу.

Б.Бат-Эрдэнэ: Нэмэлт хариулт өгье. Зарим мод үржүүлгийн иргэн, аж ахуйн нэгжүүд маань төрийн худалдан авах ажиллагааг хүсээд байгаа юм. Бид нар бол төрийн худалдан авах ажиллагааны эсрэг байгаа. Дараагийн нүүрс, дараагийн ЖДҮ, дараагийн Хөгжлийн банкны хэргийг бид нар үүсгэмээргүй байгаа. Тийм учраас бодлого, агуулга, концепцын хүрээнд бид нар төрийн худалдан авалтаас илүү эдийн засгийн эргэлтийг бий болгохтой холбоо бүхий асуудал, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаатай холбоо бүхий асуудлыг бид нар хөндөж байгаа.

Бүгд Найрамдах Хятад Ардын тухай дөнгөж саяхан бас Ганбат гишүүн ярьсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улс цөлжилтийн эсрэг 70 жил тэмцэж байгаа ард түмэн. 70 жилийн өмнөөс бодлого нь гарсан. Эхний 10 жил бол мод тарих, ургуулах, цөлжилтийн эсрэг авч байсан арга хэмжээнүүд маш их хэмжээний алдагдал хүлээсэн гэдгээ тухайн орон өөрөө бас хүлээн зөвшөөрдөг. Бид нар энэ алдааг давтаж болохгүй. Бид нар хаа холын Германаас байдаг юм уу, Австралиас бид нар хэрхэн мод тарих вэ гэдэг тухай асуудлыг хамтын ажиллагааны хүрээнд хөөцөлдөж яваад ч хэрэггүй. Бид нар ерөөсөө л Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хамтын ажиллагааны хүрээг л өргөжүүлэх. Тийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар цөлжилтийн эсрэг Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын хамтын ажиллагааны төв бас байгуулагдахаар болоод энэ бүх санхүүг нь бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас даахаар болоод явж байгаа юм.

Тэгэхээр “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээний бас нэг том ололт, энэ эдийн засгийн эргэлтийг хэрхэн бид нар бий болгох вэ, хэрхэн бид нар олон улсын зах зээл дээр байгаа Карбон маркет 234 тэрбум ам.долларт оччихсон байгаа энэ олон улсын мөнгө, төсөл, хөтөлбөрүүдтэй бид нар хэдэн хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлэх вэ, хэдхэн уур амьсгалын өөрчлөлтийн сан дээр байгаа 64 тэрбум, эргэлтэд очсон 64 тэрбум ам.долларын хэмжээн дээр бид нар энэ модтой холбоотой, устай холбоотой асуудал, байгаль орчинтой холбоотой экологийн асуудлуудаа бид нар хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудлуудыг бид нар шийдвэрлэхээр ажиллаж байгаа гэсэн үг.

Мод үржүүлгийн талбайтай холбоотой асуудал бол энийг бид нар нэг зүйлийг маш сайн ойлгох ёстой. Мод үржүүлгийн талбайг бид нар олгохын тулд хүссэн ч, эс хүссэн ч бид нар усаа дагана. Усаа дагана. Тэгэхээр бид нар устай мод үржүүлгийн талбай байгуулагдах газар бид нар хэрхэн ямар усыг ашиглах вэ гэдэгтэй холбоо бүхий асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ойн агентлаг, Усны агентлагтайгаа хамтын ажиллагааны хүрээнд хараад, шийдээд явж байгаа.

Б.Саранчимэг: Баярлалаа. Бат-Эрдэнэ сайдаа тэгэхээр бид нар олон улсын жишгээр энэ ногоон байгууламжийг нэмэгдүүлэхийн тулд бид нар яг энэ эдийн засгийн эргэлт, энэ төр, хувийн хэвшлийнхээ хамтын ажиллагаагаа илүү их өргөжүүлж цаашидаа бас энэ “Тэрбум мод”-ныхоо хөдөлгөөнийх нь үйл ажиллагааг илүү идэвхжүүлэхийг бас хүсэж байна. Гол нь бид нар бас байгаа модоо хайрлаж

хамгаалах, нөхөн сэргээх дээр.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ сайд та түр байж байгаарай. Цаг дууссан уу? Саранчимэг гишүүнд баярлалаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын иргэдийн төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын “Хобби” сургуулийн 11-ийн “А” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, амьдрал, сурлагад нь өндөр амжилт, сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Бас иргэддээ хэлэхэд энэ 5 дахь өдрийн үдээс хойших хуралдаан буюу 14 цагаас Ерөнхий сайдын мэдээллийг сонсдог. Энэ үед бол зөвхөн сөрөг хүчин асуудаг. Ингээд сөрөг хүчнийг төлөөлж Салдангийн Одонтуяа дарга асуулт асууж, Засгийн газрын гишүүнээс хариулт авна. Монгол ардын намын бүлгийг төлөөлж Батсүхийн Саранчимэг гишүүн авдаг. Хоёр гишүүн асуулт хариулт авч мэтгэлцдэг ийм дэгтэйгээр явагддаг гэдгийг бас та бүгддээ бас хэлье гэж бодож байна.

Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа Засгийн газрын гишүүнээс асуулт асууна. Нийт хугацаа 20 минут. Асуулт хариулт.

С.Одонтуяа: Зочдодоо баяр хүргэе. Гайхаж байж магадгүй. Яагаад танхимд цөөхөн хүн сууж байгаа юм гээд. Тэгэхээр өнөөдөр 5 дахь өдрийн үдээс хойших дэгээр бол намын бүлгээс 1,

1 хүмүүс суугаад намын бүлгээ төлөөлж асуудаг ийм дэгтэй байгаа. Бас гайхаж магадгүй нэг орж ирэхэд гишүүд нь байхгүй гээд.

Би нэлээн олон асуулт асуух гэсэн юм. Заримыг нь бэлэн биш бол надад бичгээр ирүүлчхэж болно.

Нэгдүгээр асуулт бол энэ Монгол орны байгалийн нөөц нэлээд буурч байгаа үзүүлэлт байгаа. Жишээлэхэд 13 онд 1 тэрбум 313 сая куб метр байсан бол 22 онд буураад нийт 67 сая куб метрээр буурчихсан гэж байгаа юм. Тэгэхээр үүний шалтгаан нь юу юм бэ гэдгийг асууя.

Хоёрт энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн хэрэгжиж эхэлснээс хойш улсын төсвөөс ер нь нийтдээ хэчнээн төгрөгийн хөрөнгө, мөнгө гарсан юм бэ? 24 онд хэдэн тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөгдөж байгаа вэ? Тэгээд энэ гарсан хөрөнгийг ер нь яаж мониторинг, хяналт хийдэг юм бэ гэдгийг тодорхой асууя. Бас нэг асуудал бол энэ төрийн өмчит болон бусад аж ахуйн нэгжүүдийн гаргасан хөрөнгийн талаар бас мэдээлэл авъя. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламжаас энэ яг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд зориулж хэчнээн төгрөгийн ер нь хөрөнгө мөнгө авсан юм байдаг юм бэ гэдгийг энэ хэдийг эхлээд асуугаад хариултаа авчихъя.

Л.Мөнхбаатар: Одонтуяа дарга асуугаад хариулаад явж болно шүү. Одоо Бат-Эрдэнэ сайдын микрофоныг өгчих. 84-ийг үү тээ? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье.

Б.Оюунсанаа: Баярлалаа. Одонтуяа даргын асуултад хариулья.

Тэгэхээр ойн нөөц ингэж буурсан энэ тоог дурдах юм бол хамгийн гол нь Монгол орны ойн санд доройтол учруулдаг хоёр том хүчин зүйл бий. Ойн түймэр, ойн хөнөөлт шавж. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын бас түрүүний мэдээлэлд гарсан 2023, 22 онд нийтдээ 730 гаруй мянган га талбай хөнөөлт шавжид өртсөн, түймэрт өртсөн энэ талбай эдгээрээс улбаатайгаар ойн талбай, тэр дундаа ой моддын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг. Үүнийг бид нар нөөцөлж шилжүүлээд тооцох юм бол энэ бууралт маань үүнээс улбаатай гарсан байгаа юм.

Хоёрдугаар асуултад буюу энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд ер нь хэдий хэмжээний төсөв зарцуулагдаад байгаа юм бэ гэж. Би энэ дээр улсын төсвийн тоог эхлээд дурдаадахъя. 2022 онд зөвхөн “Тэрбум мод” биш ойн аж ахуйн арга хэмжээ буюу түймэр, хөнөөлт шавж, мод тарих “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн бүгдийг нь оролцуулаад энэ арга хэмжээд 9 тэрбум төгрөг, 2023 онд 13.9, 2024 онд бид 34.9 тэрбум төгрөгийг төлөвлөж байна. Үүн дээр бас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд эндээс зарцуулагдана. Дээрээс нь хөнөөлт шавжтай тэмцэх ажил гэсэн энэ 2 ажил дээр голлон мөн түүнчлэн бусад ойн аж ахуйн арга хэмжээнд ойн цэвэрлэгээ, арчилгаа, мод үржүүлгийн газар, тарьц суулгац мөн ой хээрийн түймрийн урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх зэрэг аж ахуйн ажлууд ороод явах байгаа юм.

Ер нь нийтдээ энэ 13.9 их наяд төгрөгийн ингээд тооцоо гарч байгаа энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор энэ маань мэдээж бас тоймчилсон тооцоо.

Ер нь бид энэ эх үүсвэрийг бүрдүүлэх тал дээр юу гэж харж байгаа вэ гэхээр олон улсын хөтөлбөрөөс бид нар тухайлбал, Монгол, Солонгосын Засгийн газар нийтдээ 20 гаруй жилийн хугацаанд энэ ойн салбарт маш эрчимтэй хамтарч ажиллаж байгаа.

Ялангуяа цөлжилт газрын доройтолтой тэмцэх ажил дээр Азийн ойн хамтын ажиллагааны байгууллагатай 1 сая доллар, Монгол, Солонгосын Засгийн газрын хамтарсан “Ногоон хэрэм” гээд төсөл нийтдээ 12 дахь жилдээ үргэлжлээд явж байгаа энэ төслийн хүрээнд 3 дугаар шатных нь хүрээнд бид 9 сая ам.доллар-ыг өнгөрсөн оноос хэрэгжүүлж эхлээд явж байна. Энэ 4 аймагт яг энэ мод үржүүлгийн газар, ойн нөхөн сэргээлтийг дэмжих зорилгоор явж байгаа энэ төсөл. Гэх мэтчилэн бид энэ төсөл, хөтөлбөрүүдийг яг энэ “Тэрбум мод” болоод ойг нөхөн сэргээх, цөлжилтийн эсрэг яг шууд утгаар нь хэрэгжиж байгаа төслүүдийг дурдвал энэ байж болж байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт дээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд маш тодорхой хэлсэн. Юу гэхээр бид гадаадад ийм бололцоонууд байна, дэлхий дээр ногоон эдийн засаг, ногоон чиг хандлага руу явж байгаа энэ цаг үед энд гарч ирж байгаа боломжууд бидэнд бий. Тэгэхээр нүүрстөрөгчийн зах зээл гэж энэ том зах зээл гээд энэ дээр бид бас нэлээдгүй олон хэлэлцээр бас төлөвлөлтүүд, яг газар дээрх судалгаа, Мнгол орны тодорхой бүс нутаг дээрх нүүрстөрөгчийн зах зээлийн боломжийн судалгаануудыг ингээд хийгээд явж байгаа.

Мөн дээрээс нь бид нэн тэргүүнд хийх шаардлагатай юм бол дотоодын

ийм зохицуулалтуудыг хийх хэрэгтэй. Бодлого нүүрстөрөгчийн зах зээлийн бодлогоо илүү нарийвчилж тодорхойлох, талуудын оролцоотой энэ ажлыг хийх шаардлагатай байгаа. Энэ дээр бид бас бусад холбогдох яамнуудтай нягт хамтраад ажиллаж байгаа. Бас дөнгөж саяхан болж өнгөрсөн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн 28 дугаар чуулган дээр энэ асуудлууд маш ихээр хөндөгдөж, яригдаж бидэнд олон улсын зах зээл дээрээс мөнгө татах бололцоо байгаа гэдгийг харагдаж байгаа ийм зүйл бий. Баярлалаа.

С.Одонтуяа: Энэ манай гишүүд бас нэлээд энэ говийн бүстэй холбоотой асуултуудыг асуусан юм. Жишээлэхэд энэ Монгол орны ой бүхий бүс болон говийн бүсэд ер нь 1 мод тарихад гарах зардлын ийм харьцуулсан хэмжээ хэд байдаг юм бэ гэж? Тэгээд энэ говийн бүсэд мод тарьж ургуулахад шаардагдах тэр усны нөөцийг хэрхэн бүрдүүлдэг юм, гадаргын усыг бүрэн ашиглах усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх талаар ямар ямар бодитой ажлууд хийгдсэн бэ гэж гишүүд асуусан байна. Энэ хоёрыгоо эхлээд бас харилуулаа авчихъя.

Б.Оюунсанаа: Ер нь тарьц суулгац ургац байгаа орчноос хамаараад бас сайдын түрүүн хэлсэнчлэн бас бүс бүсээрээ өөр байдаг үнийн, өртгийн хувьд. Ойн бүсэд тарьж ургуулах зардал харьцангуй бага байхад говь, хээр, цөлийн бүсэд өндөр байдаг. Энэ нь болохоор усжуулалт болоод хөрс бусад арчилгааны зардалтай холбоотойгоор бидний гаргасан тооцоогоор дунджаар 20.6 мянган төгрөг бол 1 модонд гарч байгаа. Үнэ говь хээр ялангуяа цөлийн бүс рүү 37 мянган төгрөг модыг тарьж

ургуулах I мод ширхэг модны тарьж ургуулахтай холбоотой зардал гарч ирж байгаа.

С.Одонтуяа: Дэвшилтэт техник технологи.

Б.Оюунсанаа: Баярлалаа. Дэвшилтэт дэвшилтэт техник технологийн хувьд яахын аргагүй бид яг энэ ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага болоод хүний энэ чиглэлээр ажилладаг хүмүүсийн хувьд бас харьцангуй цөөхөн учраас яахын аргагүй техникийн дэвшлийг оролцуулах шаардлагатай байгаа. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэр дээр бид тухайлж яриамаар байна. Энд юу гэхээр жилдээ 10 сая ширхэг тарьц суулгацыг үйлдвэрлэх хүчин чадалтай ийм автомат мод үржүүлгийн газар бүхий системийг бид худалдаж авахаар энэ процесс нь явагдаж байгаа. Энэ юу вэ гэхээр энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бид нар дэвшилтэт технологийг Монгол Улсаа нутагшуулах шаардлагатай гэж үзээд явж байгаа. Энэ ажил маань 2024 онд хэрэгжээд явах байх. Холбогдох ажиллагаанууд нь явагдаж байгаа. Мөн “Эрдэнэс Тавантолгой” мөн “Оюу толгой” гэдэг томоохон дүнтэй мод амласан энэ аж ахуйн нэгж байгууллагуудаас бид нар энэ замаар Эрдэнэтийн хувьд болохоор хойд бүс буюу уулын ойн эко системийг хангах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой”, Оюутолгой хувьд болохоор өмнөд бүсийн энэ ойн генетик нөөцийн төвийг байгуулах, түүнтэй холбоотой дэвшилтэт технологийг нэвтрүүлэх тал дээр бид нар хамтран төлөвлөлтүүдийг хийгээд явж байгаа. Зарим ажлууд нь хийгдээд нэлээн эхэлчихсэн ийм байдалтай явж байгаа. Баярлалаа.

Б.Бат-Эрдэнэ: Нэмж яриулчихъя. Нэмээд хариулчихъя. Ер нь “Тэрбум мод” ургуулахад бид нарт жилдээ 400 сая шоо метр ус шаардлагатай байгаа юм. Усалгаанд зарцуулагдах ёстой байгаа юм. Манай орны хувьд нийт усны 0.071 орчим хувийг гадаргын усны нөөцийн 1.16 хувийг эзэлнэ гэдэг ийм тооцоо, судалгаа байдаг. Ялангуяа модны усалгаа дээр бол энэ мод өөрөө хаана байрлалаасаа шалтгаалаад мөн модныхоо төрлөөс шалтгаалаад зарцуулах литр, жил нь өөр өөр байдаг. Энэ навчит модны хувьд жилдээ бол 300-550 литр ус зайлшгүй шаардлагатай болж байдаг. Энэ цэнэг усалгаа дээр бол 100-150 литр, ургалтын үе дээр 200-350 литр гэдэг ч юм уу. Тэгэхээр саяын нөгөө литр усныхаа өртгөөр хэмжигдээд явахаар I модны жилийн арах зардалтай холбоотой асуудлууд бол шийдвэрлэгдэх.

Модны усалгааны бол аргууд байдаг. Бид нар сонгонд хүргэх, шангийн усалгаа, дуслаар услах гэх мэтчилний ийм 3 төрлийн арга бол Монгол Улсад хэрэглэгдээд явдаг. Энэ олон улсад ч ийм байдаг. Сүүлийн үед бол бид нар энэ усалгаатай холбоо бүхий асуудлыг анхаарахгүй бол бас болохгүй түвшинд, ялангуяа энэ хот суурин газрын хувьд бол энэ дуслаар услах аргыг бол зайлшгүй хэрэглэх шаардлагатай. Барилга, хот байгуулалтын яаман дээр Хот суурин газрын ногоон байгууламжийн тухай хууль явагдаж байгаа. Ер нь өргөн барих ёстой болж байгаа.

Энэ Хот, суурин газрын ногоон байгууламжийн тухай хуулиар эрх зүйн орчин бүрдээд эхлэх юм бол бид нар жилдээ хэрэглэгдэх усны хэмжээ болон өртөг судалгаа, бусад асуудлуудыг бол бид нар бүрэн дүүрэн гаргаж боломжтой гэж үзэж байгаа. I га

талбайд бол бид нар 2500-3500 ширхэг мод тарих боломжтой. Энэ 1 га талбайд тарьж байгаа модыг саяын литр усаар нь үржүүлээд бодоод үзвэл бид нарын нийт усны хэмжээ гарна. Ер нь бол яах вэ 1 тэрбум мод тарьж ургуулах энэ тоон дүгнэлтүүдийг харахад бол бид нарт 290 мянгаас 400 мянган га талбай “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бид нарт шаардлагатай нийт. Энэ нь өөрөө 29-өөс 40 мянган км квадрат газар нутгийг хамарна гэдэг ийм тооцоо судалгаанууд байдаг.

Техник дэвшил, технологийн хувьд бол ерөөсөө л цөөхөн хэдхэн зүйл бий. Нэг нь бол жишээлбэл, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын ашиглаж байгаа уулын орой дээр усан сан байгуулах. Усан сан байгуулахдаа нөгөө илангаар жишээлбэл, тодорхой автомат систем нэг хэсэг нь, нөгөө хэсэг нь бол механик аргаар, гар хэлбэрээр явах. Тэр нь өөрөө мотор байрлуулах томоохон гол мөрнүүдийг түшиглэсэн байдал дээр бол энэ усжуулах системийн ажлууд бол явж байгаа гэж хэлж болно. Техник технологийн хувьд бол ер нь бол маш ойлгомжтой л хэлбэр дээр явж байгаа.

С.Одонтуяа: Энэ та хэд хэллээ шүү дээ. Жилдээ 10 сая суулгацыг бэлэн болгох чадалтай нэг ийм зүйл худалдан авах гэж байгаа гээд. Тэгэхээр энэ чинь юу юм? Ийм хүлэмж маягаар юм уу, эсвэл гидропоник маягаар тарих юм уу, эсвэл тийм машин юм уу? Үүнийг яг юу худалдаж авах гэж байгаа юм нь нэгдүгээрт?

Хоёрт тэр Сингапурын амжилтын нууц гээд ном дээр байсан Ли Куан Ю гээд Ерөнхийлөгч нь тухайн үед

улс орноо тэр цэцэрлэгжүүлэхэд бүүр бүх модыг гаднаас авчирсан модоо бүгдийг нь өөрөө бүрчлэн бас ургаж байна уу, үгүй юү гэдэг дээр их хяналт тавьж байсан гэж нэлээн л чимхлүүр зүйл рүүгээ ордог тийм удирдагч юм байна лээ. Тэндээс маш олон мод нь ургаагүй гэж. Тэгэхээр зарим хүмүүс ингэж ярих юм. Энэ мэргэжлийн хүмүүс яг юу гэж үздэг юм бол? Гаднаас мод авчирч ургуулах нь өөрөө их эрсдэлтэй. Яагаад гэхээр манай Монгол орны нөхцөлд ургаж байгаа моднууд ингээд усаа зохицуулахад сурчихсан байдаг. Гэтэл гаднаас янз янзын моднууд тэр чийгтэй орны мод авчраад суулгахаар тэр чийгийг нь шууд хуу татаад нөгөө бусад модондоо халтай энэ тэр гэсэн юм ярьдаг юм. Тэгэхээр яг мэргэжлийн хүмүүс энийг юу гэж үздэг юм болоо?

Б.Бат-Эрдэнэ: Нэмж хариулъя. Тэр 10 сая мод автомат үйлдвэртэй холбоотой асуудал бол Эрдэнэт үйлдвэр дээр явж байгаа ийм төсөл. Өөрөөр хэлбэл “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эрдэнэт үйлдвэр маань 100 сая мод тарьж ургуулах ийм амлалт авсан. Тэр 100 сая мод тарьж ургуулах амлалтын нэгээхэн хэсэг. Өөрөөр хэлбэл бүрэн автоматажсан ийм үйлдвэр байгаа юм. Өнгөрсөн намар бид нар шавыг нь тавьсан. Швейцараас гэж явж байгаа байх тээ, Швед билүү, Швед, Шведийн ийм үйлдвэр энэ бол 10 хүн ажиллаад жилдээ 10 сая модод тарьч, суулгацыг бэлдэх ийм бүрэн гэж явж байгаа ийм төсөл байгаа юм.

Сингапурын хувьд яах вэ мэдээж манай оронтой харьцуулахад уур амьсгал шал өөр. Манай улс бол Ойн тухай хуулиар импортын модыг хориглодог. Зөвхөн судалгаа шинжилгээний зориулалтаар буюу авчраад 1 жилийн

хугацаанд тухайн мод үржүүлгийн газар дээрээ зөвхөн тарьж ургуулах хэлбэр дээр тодорхой тест, судалгаа, эрдэмтэн судлаач, мод үржүүлгийнхэн маань хийдэг. Үүн дээр бол нөгөө нянтай холбоо бүхий асуудлууд, бактеритай холбоо бүхий асуудлууд, зарим мод бол жишээлбэл, өөрөө ургахын тулд хажуу талынхаа хөрсийг, хажуу талынхаа модны шим тэжээлийг шимж ингэж амьдардаг ийм модны төрөл хүртэл байна. Нөгөө паразит гэж нэрлэдэг.

Тэгэхээр бид нарын хувьд бол яах вэ Монгол Улс бол бид нар түрүүн хэлсэн Монгол Улсын нийт 1564116 км квадрат газар нутгийг бид нар 3 хувааж байгаа. Цөлжилтөд нэрвэгдчихсэн бүс 21 хувь, цөлжилтөд нэрвэгдэж яваа бүс, ногоон бүс. Тэгэхээр бид нар ногоон бүс рүүгээ бол гаднаас импортын модыг бид нар оруулахгүй, оруулахгүй. Ойн тухай хууль дээр бид нар тодорхой эрдэмтэн, судлаачидтайгаа ярилцаад явж байгаа зүйлүүд бий. Манай мод үржүүлгийн компаниудын хувьд бол гаднаас мод оруулаад ирэхээр бид нарын бизнес зогсоно гэдэг ийм хардлага нэг талдаа байдаг. Бид нарын хувьд бол жилд тэрбумаар тоологдох модыг тарьж оруулахын тулд жилд 130-150 сая ширхэг тарьц, суулгац бид нарт нэн яаралтай хэрэгтэй байна.

Гэтэл мод үржүүлгийн компаниуд, иргэн, аж ахуйн нэгжүүд маань бол жилдээ өнөөдөр бүүр нэмсээр байж байж л одоо дөнгөж 62 саяд ирж байна. Дараа жил бид нар 120 саяд хүргэхээр төлөвлөж байна double-дахаар гэх мэтчилнээс авхуулаад бид нар тодорхой хэмжээний асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болж байгаа. Эрдэмтэн, судлаачдын хувьд яг таны хэлсэнчлэн хөрсөө иддэг, хөрсийг

доройтуулдаг мод, хажуу талынхаа модонд паразит хэлбэрээр нөлөөлдөг мод, хэт их ус шаарддаг мод гэдэг ч юм уу маш олон төрлийн судалгаа шинжилгээний ажлуудыг танилцуулдаг. Бид нар нэгэнт цөлд нэрвэгдчихсэн, цөлжчихсэн байгаа газар нутаг дээр бид нар арай өөр арга хэмжээ авах ёстой гэж Байгаль орчин, аялал жуулчлалын яам үзэж байгаа. Үүнийгээ ч бид нар эрдэмтэн, судлаачидтайгаа нээлттэй ярилцаж байгаа.

Тухайлах юм бол, өнөөдөр бид нар Сингапур шиг чийгтэй газар ургадаг мод оруулж ирэхээс илүүтэйгээр бид нар өөрсдөө цөлд тэсвэртэй, цөлийн нөхцөл байдал, усгүй нөхцөл байдалд тэсвэртэй модны сортыг бид нар гаргаж авах шаардлагатай байгаа. Үүнийг бид нар Монголын эрдэмтэн, судлаачдыг гаргаж ирээч гэж хүсэж байгаа. Үүнийг бид нар хийхгүйгээр нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжилтөд нэрвэгдэж байгаа энэ цаг хугацаанд бол тодорхой хэмжээнд бид нар дараа дараагийн бодлогын арга хэмжээнүүдийг авах нэн шаардлага цаг хугацааныхаа зарчмаар ингээд л тулгарч байна л гэсэн үг.

С.Одонтуяа: Ойлголоо аанхан. Нэг ийм зүйл асуух гэсэн юм. Энэ Монгол Улсаас энэ экспортолж байгаа ойн дагалдах баялаг гэж байгаа тээ? Тэгэхээр ойн дагалдах баялгийн ер нь төрөл, хэмжээ ямар байдаг юм? Ялангуяа энэ хушны самрыг экспортоод байгаа.

Тэгэхээр үүн дээр ямар бодлого баримталдаг юм? Экспортод савлагаатай бас гаргаад байгаа шүү дээ нэлээн. Тэгэхээр энэ чиглэлээр экспортод энэ бизнес нь хөгжих ямар боломж байдаг юм, эсвэл яг танайхаас ямар

бодлого баримталж байгаа юм яг энэ ойн дагалдах баялаг дээр?

Б.Бат-Эрдэнэ: 2022 онд бид нар Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газартай энэ хуш самрын экспортын холбоо бүхий асуудлуудыг бид нар хөндөж албан ёсны уулзалтуудыг хийж байсан. Засгийн газрын Хэрэг эрхлэхээс ч бас маш сайн анхаар гэдэг ийм үүрэг чиглэлийг өгсөн байдаг.

Яагаад энэ дээр ийм асуудлууд үүссэн бэ гэхээр 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 33 мянган тонн зөвшөөрөл олгосон байхад 40 мянга орчим гарчихсан ийм 600 орчмын зөрүү гарч байсан. Энэ яагаад гадагшаа гарсан бэ, энэ бүртгэл хаана байна вэ нөгөө нүүрсний хулгай гэдэг шиг хэлбэр биш биз дээ гэдэг бодлого агуулга, концепцын асуудлууд хөндөгдсөн. Манайх 1 кг тутамдаа гарч байгаа самрын тоо хэмжээ ингээд дэлхийн тооцооллоо хийгээд үзэхээр эхний 8 орон дотор экспорт дотор Монгол Улс байдаггүй. Эхний 20 дотор ч байхгүй. Эхний 8 дотор гэхэд жишээлбэл, 8 дугаар байранд Европын нэг орон ордог. Тэр бол 437 тонн ч билүү ийм самар нийлүүлдэг гэдэг ийм тооцоо, судалгаа байдаг юм байна лээ. Монгол Улс гэтэл байдаггүй.

Энэ юу гэсэн үг вэ гэхээр Монгол Улс ченжийн орон болсон байна гэсэн үг. Манай самрууд Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу ченжийн хэлбэр дээр явж байна. Үүнийг бид нар хаанаас тодорхойлсон бэ гэхээр тарифтай холбоотой асуудал хөндөгдөж байгаа юм. 1 кг тутамд билүү, 1 тонн тутамд билүү нөгөө 1 аравны хэдэн доллар чинь? 1кг тутамд 1.6 доллар, 1 кг тутамд 1.6 доллар байсан. Уртнасан сайдын үед үүнийг 6 доллар болгосон байдаг.

Өнгөрсөн 2022 онд бид нар үүнийг 12.67 доллар болгосон байдаг. Ингээд өгсөх ёстой. Энэ бол нөгөө Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Хуш самартай холбоо бүхий...

С.Одонтуяа: Хураамжийнх нь хэмжээ юм уу тээ?

Б.Бат-Эрдэнэ:...нөгөө худалдаалж байгаа үнэ гэсэн үг. Таны саяын хэлсэн нөгөө савлагаатай самартай холбоотой асуудал дээр жишээлбэл, эсрэг талд нь явж байна гэсэн үг. Монгол дотооддоо савлагаатай хэлбэр дээр дахин боловсруулаад НӨАТ шингээгээд олон улсад экспортод гаргах тухай бодлого, хөтөлбөр явж байтал нөгөө түүхийгээр нь гадагшаа гаргах процесс нь дийлэнх хувьдаа явагдаж байгаа. Энэ өөрөө эргээд нөгөө экспорт гэдэг зүйл дээр нөлөөлдөг ийм хэлбэр. Нэг нь бол НӨАТ шингэсэн, нөгөөдөх нь НӨАТ шингээгүй ийм хэлбэр гэсэн үг.

Тэгэхээр энэ дээр бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 88 гаран аж ахуй нэгж энэ самрын экспортын зөвшөөрөл авсан байсан. Үүнийг бол бид нар 16 болгож бууруулах, цаашилаад бид нар бол зөвхөн самрын үйлдвэртэй газрууд дээр энэ үйл ажиллагаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэдэг ийм бодлого, концепцыг бид нар явуулж байгаа. Энэ тухайлах юм бол өрсөлдөөний хэлбэрт нөлөөлнө шүү дээ гэдэг ийм зүйл яригдаад эхэлж байгаа юм. Тэгээд бид нар хяналтын ажлын хэсэг шалгалт явуулаад эхлэнгүүт нэг нь үйлдвэртэй, дахиад хоёр газарт аж ахуйн нэгжид зөвшөөрөл өгчихсөн.

Гэтэл тэр үйлдвэртэй аж ахуй нэгж нь зөвшөөрөл авчихсан байтал

нөгөө 2 хоёр аж ахуйн нэгжид бид нар түрээсэлдэг гэдэг хэлбэр дээр гэрээ байгуулж өгөөд, тэр нь дахиад зөвшөөрөл авчихсан гэх мэтчилний. Хоёрхон хүн ажилладаг компани байгаа юм. Захирал, нягтлан.

Гэтэл энэ компани зөвшөөрөл авдаг, самар гаргадаг. Ямар ч ажилчин, албан хаагчийн нийгмийн даатгал төлдөггүй, эрүүл мэндийн даатгалд төлдөггүй, татвар төлдөггүй. Эргээд татварын байгууллагын гаргасан тооцоо, судалгаагаар харахаар нийт 10. Жишээлбэл, 10 төгрөгөөр самрыг олж байлаа гэж тооцоход зарж байгаа нь 5 төгрөг. Яагаад алдагдалтай ажиллаж байгаа гэх мэтчилэнгээс авхуулаад энэ асуудлыг шийдвэрлэхээр эхнээс нь хууль.../минут дуусав./

С.Одонтуяа: Минут бага болчихсон байна. Сүүлийн асуулт асуучихъя. Энэ ойн салбарын эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох, мэргэжилтэн, хүний нөөц бэлдэх талаар яг хийсэн тодорхой ажлууд байна уу? Ер нь ойрын үед яг энэ чиглэлээр юу хийх гэж байна, гол эрх зүйн зохицуулалт?

Б.Бат-Эрдэнэ: Унтарчихсан байна. Би хэлчихье. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга, төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд бол бид нар хэд хэдэн концепцыг оруулж өгч байгаа. Ялан.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Цаг дууссан байна. Асуулт хариулт 20 минутад багтаан явагддаг. Одонтуяа гишүүн Ардчилсан намын бүлгийг төлөөлж асуулт асууж, хариулт авлаа. Монгол ардын намын бүлгийг төлөөлж Саранчимэг гишүүн асуулт асууж, хариулт авсан. Ингээд Одонтуяа дарга,

Саранчимэг гишүүн хоёр баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Ажлын хэсэгт баярлалаа.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.43 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

